



БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

ᠨᠢᠶᠢᠭᠮᠢᠶᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯᠠᠨ ᠭᠠᠰᠠᠷ
ᠨᠢᠶᠢᠭᠮᠢᠶᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯᠠᠨ ᠭᠠᠰᠠᠷ

ᠨᠢᠶᠢᠭᠮᠢᠶᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯᠠᠨ ᠭᠠᠰᠠᠷ
ᠨᠢᠶᠢᠭᠮᠢᠶᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯᠠᠨ ᠭᠠᠰᠠᠷ



1. Статистик мэдээ
2. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн, хүрсэн түвшин
3. Иргэдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлсэн байдал
4. Дүүргийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын биелэлт
5. Байгууллагын удирдлагын манлайлал, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсэн байдал
6. Санхүүгийн зөрчилгүй, төсвийн өр авлагын талаарх мэдээлэл
7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тайлан мэдээний чанар, хугацаа
8. Дүүрэг болон байгууллага орчноо тохижуулах чиглэлээр хийсэн ажил
9. Ажилтнуудын ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал
10. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн
11. Үйл ажиллагаагаа иргэд, даатгуулагчдад сурталчилсан байдал, зохион байгуулсан сургалт сурталчилгаа, үр дүн

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 10

Багануур дүүрэг

ЭХЛЭЛ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь тайлант хугацаанд шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан Нийгмийн даатгалын тухай хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн захиргааны удирдах дээд шатны байгууллагуудаас гаргасан тушаал, захирамж, тогтоол, шийдвэр, албан даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг ханган ажиллав.


Тайлант хугацаанд ажил олгогч даатгуулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалж, хууль дээдлэн, бусдын нөлөөнд үл автан ажиллах зарчмыг баримтлан, дүүргийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг зохих сангаас, хуулиар тогтоосон цаг хугацаанд тогтоон, Sicos цахим системээр бүртгэж олголоо.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/38 дугаар тушаалаар тайлант оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласны дагуу шимтгэлийн өр авлагыг бууруулах чиглэлээр анхааран ажиллаж байна.

Тайлант онд өмнөх жилийн санхүүгийн жилийн тайланг шинэ цахим систем, Sicos програмаар гаргах, цахим системийн хөгжүүлэлт, сайжруулалт хийх, их ажлын жил болж байна.

НЭГ. СТАТИСТИК МЭДЭЭ

2025.11.30-ны өдрийн байдлаар



ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН, ХҮРСЭН ТҮВШИН

2.1 Нийгмийн даатгалын орлогын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, санхүүгийн үзүүлэлтийн талаар

2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 38,154.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 33,050.9 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 86.62%-иар биелүүлэв. /ЭМД санд 4,960.2 сая төгрөг төвлөрүүлсэн./

				/сая.төг/-өөр
	Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Тэтгэвэр	31,840.9	26,852.7	84.33
2	Тэтгэмж	2,785.5	2,851.5	102.3
3	ҮОМШӨ	2,457.9	2,314.0	94
4	Ажилгүйдэл	1,070.2	1,005.5	93.96
5	Эрүүл мэнд		4,960.2	

2.1.1 Орлого, шимтгэл, хамралт

2025 онд шинээр хамруулах ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо баталсан төлөвлөгөөгөөр ажил олгогч 18, албан журмын даатгуулагч 108, сайн дурын даатгуулагч 151 гэж баталснаас 2025 оны тайлант хугацаанд 14 ажил олгогч, албан журмын 109 даатгуулагч, сайн дурын даатгалд 322 даатгуулагчийг шинээр хамруулсан байна. Төлөвлөгөөний биелэлт ажил олгогч 77,7 хувь, албан журмын даатгуулагч 100.9 хувь, сайн дурын даатгуулагч 211 хувийн гүйцэтгэлтэй байна.



2.1.1.1 Албан журмын даатгалын хамралт, орлого бүрдүүлэлт:

2025 оны 12-р сарын 08-ний өдрийн байдлаар 159 байгууллагын 6,379.9 сая төгрөгийн авлага, 75 байгууллагын 411.4 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Нийт авлагын насжилтаар ангилвал :

1. 0-30 хоногтой 81 ажил олгогчийн 2,149.7 сая төгрөг
2. 31-9 хоногтой 83 ажил олгогчийн 1,162.1 сая төгрөг
3. 91-180 хоногтой 66 ажил олгогчийн 1,007.6 сая төгрөг
4. 181-270 хоногтой 18 ажил олгогчийн 7,69.6 сая төгрөг
5. 271-365 хоногтой 11 ажил олгогчийн 624.1 сая төгрөг
6. 366-730 хоногтой 11 ажил олгогчийн 482.1 сая төгрөг
7. 731-1095 хоногтой 6 ажил олгогчийн 102.5 сая төгрөг
8. 1826 дээш хоногтой 5 ажил олгогчийн 74.5 сая төгрөг байна.

Дараахь 6 ажил олгогчийн нийт авлага 5,598.3 сая төгрөг бөгөөд нийт авлагын 90.6% хувийг эзэлж байна.

Үүнд:

- Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн шимтгэлийн авлага 2,851.2 сая төгрөг нийт авлагын 44.6%, 366-730 хоногийн насжилттай,
- Багануур ХК-ний шимтгэлийн авлага 1,315.0 сая төгрөг, 0-30 хоног, нийт авлагын 20.6%,
- Багануур Дулааны станц ТӨХК-ний шимтгэлийн авлага 836.7 сая төгрөг 181-270 хоногийн насжилттай 15%,
- Соёолон групп ХХК-ний шимтгэлийн авлага 378.7 сая төгрөг 6.7%,
- Мон цахим ХХК-ний шимтгэлийн авлага 110.3 сая төгрөг, 91-180 хоногийн насжилттай 1.9%,
- Нийслэлийн ерөнхий боловсролын Оюуны эрин сургуулийн шимтгэлийн авлага 106.4 сая төгрөг 1.8%

2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын өр барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/47 дугаар тушаалын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 03 өдөр гарган Газрын даргаар батлуулан ажилласан.

Тус дүүргийн Эрүүл мэндийн төвийн шимтгэлийн өр төлбөрийг барагдуулахад хамтран ажиллах талаар Эрүүл мэндийн төвтэй шимтгэлийн өр барагдуулах гэрээ байгуулсан боловч санхүүжилт хүрэлцэхгүйн улмаас шимтгэл гэрээний дүнгийн дагуу төлөгдөхгүй, сар бүр батлагдсан төсвийн хуваарилагдсан дүн 80,0 сая төгрөгөөр өр төлбөрийг барагдуулж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн 50.0 саяас дээш төгрөгийн өртэй дараахь ажил олгогчид байна. Үүнд:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын
гүн галуут цогцолбор сургууль -99.1 сая төгрөг /0-30 хоног/
2. Нийслэлийн ерөнхий боловсролын
Боловсрол цогцолбор сургууль - 84.0 сая төгрөг /0-30 хоног/
3. Мимс ХХК- 56,9 сая төгрөг /366-730/

Нийгмийн даатгалын байгууллага 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жилийн аяны хүрээнд нийт 6 албан байгууллагыг иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжил гарган шийдвэрлүүлж 2025.11.30-ы байдлаар 1,245.9 сая төгрөгийг төлүүлэх байснаас 502.5 сая төгрөг төлүүлж, 583.4 сая төгрөгийг шүүхийн шийдвэрээр албадан гүйцэтгүүлэх хүсэлт өгсөн.

БНД ШШГХ-н хамт олонтой 2025 оны 05 дугаар сард уулзалт хийж НДЕГ-аас ШШГБ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд МИМС ХХК-ийн судалгааг Шимтгэл хураалт удирдлагын газарт 2025.11.30-ны өдрөөр тасалбар болгон судалгааг хүргүүлсэн.

Тус газарт одоогоор Багануур дүүргийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх хэлтэст “МИМС” ХХК гэх нэг аж ахуйн нэгжийн гүйцэтгэх баримт бичиг байгаа бөгөөд оны эхэнд 61.9 сая төгийн үлдэгдэлтэй байснаас эхний 11 сарын байдлаар 5.0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж ажилласан. Үлдэгдэл төлбөр 56.9 сая төгрөг байна. Тус компани шийдвэр гүйцэтгэлийн шатанд сар бүр тогтмол төлөлтөөр төлбөр хийж байгаа болно.


Банкуудтай хамтран ажиллаж нийт 5 аж ахуйн нэгжид 1 тэрбум 343.5 сая төгрөгийн данс хаасан мэдэгдэл хүргүүлсэн. Итгэлцлийн аяны хүрээнд 3 байгууллага 13.2 сая төгрөг барагдуулж данс нээсэн ба 2 байгууллагатай төлөлтийн хуваарь гарган гэрээ байгуулсан.

Итгэлцлийн аян эхлэхэд 64 байгууллагын 4,310.9 сая төгрөгийн шимтгэлийн өртэй байснаас бүрэн барагдуулсан 27 байгууллагын 64.8 сая төгрөг, гэрээ байгуулсан 20 байгууллагын 2,811.6 сая төгрөгийн авлагаас 16 байгууллагын 199.1 сая төгрөг, хэсэгчилж төлсөн 129.1 сая төгрөг, нийтдээ 393.9 сая төгрөгийг барагдуулан ажилласан.



2025 оны тайлант хугацаанд хуримтлагдсан өр бүхий 1,343.5 сая төгрөгийн өртэй 5 ажил олгогчийн дансыг хааж 1,333.9 сая төгрөгийг төлүүлсэн, 5 байгууллагын 73.7 сая төгрөгт Мэдэгдэл өгч 65.6 сая төг төлүүлсэн, 3 байгууллагын 1,748.3 сая төгрөгт Гэрээ байгуулан 571.6 сая төгрөг төлүүлсэн.

Нийт авлагыг графикаар харуулбал:



Тайлант хугацаанд 2024 оны жилийн эцсийн 84 байгууллагын 2,994.2 сая төгрөгийн авлагаас 75 байгууллагын 1,965.6 сая төгрөгийг барагдуулж авлагыг 60.4%-р бууруулсан байна.

2.1.1.2 Сайн дурын даатгалын хамралт, орлого бүрдүүлэлт:

НДЕГ-ын даргын 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/10 дугаар тушаалаар шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тоон төлөвлөгөөг баталсан. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 138 даатгуулагчийг сайн дурын даатгалд шинээр хамруулахаас тайлант хугацаанд 322 даатгуулагчийг хамруулж, төлөвлөгөөг 211 хувиар биелүүлээд байна.

Шинээр хамруулсан сайн даатгуулагчдыг төрлөөр нь ангилвал:


- малчин 22 хамруулахаас 33 хамруулж төлөвлөгөө биелэлт 165%,
- 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 33 хамруулахаас 27 иргэн даатгуулж гүйцэтгэл 90% хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ 21 хамруулахаас 11 даатгуулагчийг хамруулж гүйцэтгэл 58%,
- Энгийн сайн дурын даатгалд 75 иргэн хамруулахаас 251 иргэн даатгуулж гүйцэтгэл 364% -тай байна.

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/-ийн шимтгэлийг төрөөс төлнө. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг сайн дурын даатгалд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө. Тус зохицуулалтын хүрээнд дүүргийн хороодоос авсан судалгаагаар эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 77 эх /эцэг/ байна. Үүнээс албан журмын даатгалд 18, өндөр насны тэтгэвэрт 4 хуулиар тогтоосон болзол хангасан 36 иргэн сайн дурын даатгалд, сайн дураар даатгуулаагүй 19 эх /эцэг/ байна.

Малчны 5 хүртэл жилийн шимтгэлийн 50 хувийг төрөөс төлнө. Малчин, туслах малчин сайн дурын даатгалд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна. Тус зохицуулалтын хүрээнд дүүргийн хороодоос малчдын судалгааг авч нэгтгэхэд 997 малчин (мал бүхий иргэн) байна. Үүнээс албан журмын даатгалд 294, өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч 276, сайн дурын даатгалд хамрагдах боломжтой 427 малчин, туслах малчнаас 169 нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн зүйлийн 6, 7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 485 дугаар тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхчүүд нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн бол төлөх шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас төлөх, бусад эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс, 50 хувийг даатгуулагч эх өөрөө төлөхөөр зохицуулсан. Тайлант хугацаанд дээрх зохицуулалтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас болон улсын төсвөөс шимтгэлийг хариуцаж төлж буй 165 даатгуулагч эх байна.

Тайлант онд шинээр даатгуулагчдыг төрлөөр нь ангилан өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:



Дээрх графикаас харвал сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оноос буурсан нь 2025 оны 04 дүгээр сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилэн тогтоож, өсгөсөнөөс сард төлөх шимтгэлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тэгвэл тайлант оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1090 иргэн сайн дурын хэлбэрээр нийгмийн даатгалд хамрагдсан байна. Нийт даатгуулагчдыг төрлөөр харуулбал:

	Даатгуулагчийн төрөл	/2024.01.01- 12.01/ даатгуулагчийн тоо	/2025.01.01- 11.30/ даатгуулагчийн тоо	Зөрүү
1	Шинээр	336	284	-52
2	Даатгуулагч эх	30	27	-3
3	Хөгжлийн бэрхшээлтэй асарч байгаа эх /эцэг/	25	11	-14
4	Сунгасан	962	851	-111
	Нийт дүн	1353	999	-180

Нийгмийн даатгалын санд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1230 даатгуулагчийн 725.8 сая төгрөг, 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1090 даатгуулагч байгаа нь өмнөх оноос 12%-р буурсан, төвлөрүүлсэн 854.2 сая төгрөгийн орлого нь өмнөх өнөөс 17%-р өссөн байна.

Сайн дурын даатгалын 2024 оны массив, 471 ширхэг зогсоогдсон хувийн хэргийг хамт жагсаалтаар архивт хүлээлгэн өгч, архивын нэгж бүрдүүлэв.

Тайлант оны эхэнд 588 даатгуулагчийн 18.7 сая төгрөгийн өглөгийн бүртгэлтэй байна. Өмнөх оны эхэнд 60 даатгуулагчийн 1.2 сая төгрөгийн өглөгийн бүртгэлийг оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад өссөн байгаа шалтгаан нь системийн шинэчлэлтэй холбоотой хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй 397 даатгуулагчийн 13.8 сая төгрөгийн алдангийн шимтгэл тайлант оны эхний үлдэгдэлд бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд 907 даатгуулагчийн 42.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс системийн хөгжүүлэлт бүрэн хийгдээгүй байгаагаас шалтгаалан 2024 онд хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй 397 даатгуулагчийн 13.8 сая төгрөгийн алдангийн шимтгэл давхар бүртгэлтэй байна. Мөн 2025 онд хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй даатгуулагчдын алдангийн шимтгэл, 2025 он дуусталх шимтгэлээ төлсөн даатгуулагчдын нийт дүн байна.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 03 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000 төгрөгөөр шинэчлэн

баталж, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон шимтгэл төлж байсан сайн дурын даатгуулагчдад мэдээлэл хүргэж, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг 792,000 төгрөг болгон харгалзах шимтгэлийг тооцон төвлөрүүлж байна. Нийт даатгуулчдын 90.4% буюу 1061 иргэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр орлого тодорхойлж сайн дураар даатгуулж байна.

Нийгмийн даатгалын шинэчлэн батлагдсан багц хуулийг иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах мөн шинэ Sicos систем нэвтрүүлсэнтэй холбоотойгоор программд даатгуулагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэх, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, гэрээний төрөл шинэчлэн бүртгэх зэрэг цаг үеийн ажлуудыг гүйцэтгэж ажиллав.

2.1.1.2.1 Программын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн талаар

2025 оны 01 дүгээр сараас шинээр нэвтрүүлж буй Sicos ситемээр шимтгэлийн тайланг хүлээн авч ажиллаж хэвшсэн боловч зарим тохиолдолд шалгасан тайлангууд тайлан хүлээн авах хугацаа болсон байхад баталгаажсан төлөвт шилжихгүйн улмаас ажил олгогчийг дахин тайлан илгээлгэх шаардлага гардаг. Энэ нь ажил олгогч нарын бухимдлыг нэлээн хүргэж байна. Мөн шинээр ажил олгогч байгууллага бүртгэхэд тухайн ажил олгогч дээр 5-8 өөр ажил олгогчийн дугаар үүсч хүндрэл учруулж байсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэрэгжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.5, 1.5, 2.5%, ажил олгогчийн төлөх ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 0.5% байхаар тус тус өөрчилснийг мөрдөн ажиллаж байна.

Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс сард 792,000 төгрөг байхаар шинэчилэн тогтоосныг ажил олгогчид мөрдүүлэн ажилласан.

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл кодын жагсаалтыг баримтлан ажиллаж байна.

Шинээр батлагдсан тогтоол, журам, тушаал, хуулийн хэрэгжилтийг ханган, мөрдөж ажиллах талаар ажил олгогч, даатгуулагчдад тус газрын пэйж хуудсаар тухай бүр хүргэн, ажил олгогчийн удирдлага, хүний нөөц, санхүүгийн ажилтнуудад системд ажиллах заавар зөвлөмжийг тухай бүр өгч, хууль журмын зүйл заалтыг тайлбарлан таниулж ажиллаж байна.

Нийгмийн даатгалын тухай хууль, журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, шимтгэлийн тайланг үнэн зөв гаргах, даатгуулагчийн цалинг зөв тайлагнах, залруулга гаргахгүй ажиллах чиглэлээр ажил олгогчийн нягтлан бодогч нарт сар бүр зөвлөн туслаж, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авахдаа даатгуулагч бүрийн төрлийн кодыг зөв хэрэглэсэн эсэх үндэслэлийг нэгдсэн мэдээллийн сан даатгуулагчийн лавлагаа цэснээс нягтлан шалгаж хэвшсэнээр төрлийн код, бусад алдааг залруулан ажиллаж байна.

Ингэснээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хуулийн хугацаанд төвлөрүүлж, тайлагнах, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогчдыг мэдээллээр хангах үр дүнтэй байна.

2025 оны тайлант хугацаанд аж ахуйн нэгж, албан байгууллагаас нийт 78 албан хүсэлт ирүүлснээс шинээр бүртгүүлэх 14, цалин түүнтэй адилтгах орлогын дүнг буруу илгээсэн, тайлангийн үлдэгдэл зөрүүтэй татагдсан, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн төрөл, ажил мэргэжлийн код буруу сонгосон, даатгуулагчийг орхиж тайлагнасан, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй, буруу, илүү, дутуу тайлагнасан зэрэг шалтгаанаар 16 ажил олгогчийн ирүүлсэн албан бичиг, нотлох баримтыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Мөн байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнууд солигдсон шинээр томилогдсон албан хаагчдын бүртгэлийг системд шинэчлэх хүсэлт нийт 40 байгууллагаас ирүүлснийг шийдвэрлэн ажиллав. Нийгмийн даатгалын

шимтгэлийн “х” тайлан илгээх хүсэлтэй 8 ажил олгогчийн тайланг системд хүлээн авч ажиллаж байна.

2.2 Нийгмийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, II, III дугаар улирлын тэтгэвэр, тэтгэмжийн тайланг шинэ системээр хугацаанд нь гаргалаа.

Нийгмийн даатгалын сангийн зарлагын төсвийн гүйцэтгэл
/сая.төг-өөр/

	Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт
1	Тэтгэвэр	56,582.9	56,216.5	366.3
2	Тэтгэмж	2,738.04	2,665.8	72.194
3	ҮОМШӨ	3,701.2	2,404.0	1,297.2
4	Ажилгүйдэл	1,440.7	1,444.3	-3.6
	Дүн	64,462.9	62,730.7	1,732.1

2.2.1 Тэтгэврийн тогтоолт

Нийгмийн даатгалын багц хууль, “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”, дээд газраас ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн тэтгэмжийн даатгалын сангаас 1153 даатгуулагч, хүний давхардсан тоогоор 2698 хүсэлтийг хүлээн авч 2,614.1 сая төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас 356 даатгуулагчид 1,539.8 сая төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 340 даатгуулагч, хүний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн 308.7 сая төгрөгийн тэтгэмж, төлбөр хянаж, тогтоосон байна.

2.2.2 Тэтгэвэр олголт

2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 5368 хүнд 56,210.8 сая төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 145 хүнд 2,039.5 сая төгрөгийн, нийт 5513 хүнд 58,250.3 сая төгрөгийн тэтгэврийг олгосон нь нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх өнөөс 2%-р өсөж, төсвийн зарцуулалт 97%-тай байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн сан, ҮОМШӨ даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг-өөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Тэтгэврийн даатгалын сан					
1	Өндөр насны тэтгэвэр	46,369.2	46,248.1	121.1	99.74
2	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	3,574.0	3,389.4	184.9	94.82
3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	1,720.2	1,649.9	70.3	95.91
4	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр	4,908.4	4,923.6	-15.2	100.31
	Нийт дүн	56,572.0	56,210.8	361.1	99.36
2. ҮОМШӨ-ний даатгалын сан					

1	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	2,571.1	1,840.4	730	71.58
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	199.2	199.0	0.22	99.89
	Нийт дүн	2,770.4	2,039.5	730.9	73.62

2.2.2.1 Тэтгэвэр авагчдийн тоо сүүлийн 5 жилээр


д/д	Тэтгэвэр авагчдын төрөл	2021 он	2022 он	2023 он	2024.11.30-ний байдлаар	2025.11.30-ний байдлаар
1	Өндөр насны	3939	4221	4375	4519	4678
2	ХЧА	692	734	745	625	581
3	Тэжээгчээ алдсаны	239	260	269	257	254
	Нийт	4870	5215	5389	5401	5513

2.2.2.2 Тэтгэврийн хөдөлгөөний тоо мэдээ

Тайлант онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заагдсан тэтгэвэр тогтоолгох, мөн хуулийн 29.3, 9.2-т заасны дагуу тэтгэврийн хэмжээг өөрчлүүлэх, шилжиж ирсэн болон шилжиж явсан нийт 554 даатгуулагч иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэлээ.

д/д	Тэтгэврийн хөдөлгөөн	Өндөр нас	Хөдөлмөрийн чадвар алдсан	Тэжээгчээ алдсан	Дүн
1	Шинээр тогтоосон	204	48	13	265
2	Шилжиж ирсэн	4	2	2	8
3	Шилжиж явсан	17	7	3	27
4	Тусгай зохицуулалт	30	0	0	30

Шинээр тогтоогдсон тэтгэврийг өмнөх оны мөн үетэй төрлөөр нь харьцуулбал



2.2.2.3 Тайлант хугацаанд нас барсан 96 тэтгэвэр авагчийн гэр бүлийн гишүүнд нас барсны дараа сарын тэтгэвэр 86,105.4 сая төгрөг олгож, 30 тэтгэвэр авагчийн өндөр насны тэтгэврийг НДСОТТХ-н 9 дүгээр зүйлийн 9.3 заалтын дагуу нэмэгдүүлэн тогтоож сар бүр олгож байна.


Тусгай зохицуулалтын хүсэлтийг сараар харуулбал



2.2.2.4 Дундаж тэтгэврийн хэмжээ

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 221 тоот тогтоолоор тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлж, мөн шинэчилж батлагдсан итгэлцүүрийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс шинээр тогтоолгосон тэтгэвэрт хэрэглэснээр тус дүүргийн тэтгэвэр авагчдын дундаж тэтгэвэр дараах байдалтай болж нэмэгдсэн байна.

Улсын дундаж тэтгэвэр



Дүүргийн дундаж тэтгэвэр



2.2.2.5 Тэтгэвэр авагчийн тоог сүүлийн 12 сараар харьцуулсан судалгаа



2.2.3 Тэтгэврийн зөвлөн туслах үйл ажиллагаа

Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэл шалгуулах, шимтгэл төлж ажилласан жил хэрхэн тооцох, тэтгэвэр тогтоолгох насны болзол, тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзол, нэмэгдүүлсэн насны болзол, хөдөлмөрийн хөнгөлттэй нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол, тусгай зохицуулалт, тэтгэврийн өөрчлөлт, олголт зэрэг асуудлаар даатгуулагч, тэтгэвэр авагч иргэдэд цахимаар, утсаар болон биечлэн зөвлөгөө өгч, тэтгэвэр тогтоолгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл, зөрчлийг арилгах, урьдчилсан тооцоолол хийлгэхээр ирсэн 993 даатгуулагчид мэдээлэл зөвлөгөө өгч зөвлөмжийн хуудас 167 даатгуулагчид бичиж өгч, бүртгэл хөтлөн ажиллаж байна.


Шинэ системд урьдчилсан тэтгэврийн тооцоолол хийж зөвлөгөө өгөх боломжийг бүрдүүлж өгвөл тэтгэврийн байцаагчийн ажлыг хөнгөвчлөх, иргэд даатгуулагчийн сэтгэл ханамж нэмэгдэхээр байна.

Тус газраас тэтгэвэр авч байгаа 5347 иргэний тэтгэврийн хувийн хэрэг илүүдэл, дутагдалгүй бүрэн бүтэн тоологдсон. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн А/204 дүгээр тушаалаар шинэчилж батлагдсан маягтаар тэтгэврийн хувийн хэргийн 2025 оны жилийн эцсийн тооллогыг явуулахаар бэлтгэл ажил хангаж байна.

Өндөр насны, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн тогтоолтын хуудас /англи, монгол хэлээр/, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тодорхойлолтыг www.portal.ndaatgal.mn болон мэдээлэл солилцооны ХУР системээс цаг алдалгүй түргэн шуурхай, цахимаар авах боломжийг тэтгэвэр авагч иргэдэд зөвлөж, энэ үйлчилгээг 100% цахимаар шийдэж байна.

2.2.4 Тэтгэмж тогтоолт

Нийгмийн даатгалын багц хууль, “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”, дээд газраас ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн тэтгэмжийн даатгалын сангаас 1153 даатгуулагч, хүний давхардсан тоогоор 2698 хүсэлтийг хүлээн авч 2,614.1 сая төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас 356 даатгуулагчид 1,539.9 сая төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 340 даатгуулагч, хүний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн 308.8 сая төгрөгийн тэтгэмж, төлбөр хянаж, тогтоосон байна.



2.2.5 Тэтгэмжийн олголт

Тэтгэмжийн даатгалын сангаас 1201 даатгуулагчдад давхардсан тоогоор 2,646.8 сая төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас 399 даатгуулагчид 1,442.0 сая

төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 341 даатгуулагч хүнд давхардсан тоогоор 309.0 сая төгрөгийн тэтгэмж, төлбөрийг Нийгмийн даатгалын багц хууль, “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”, дээд газраас ирсэн зөвлөмжийн дагуу тогтоож, олголоо.


Тэтгэмжийн даатгалын сангийн мэдээ

/сая.төг-өөр/

	Тэтгэмжийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсны	649.5	685.9	-36.3
2	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох	400.1	246.0	154.1
3	Жирэмсний болон амаржсны	1,638.3	1,714.8	-76.5
	Дүн	2,688.0	2,646.8	41.0

2.2.5.1 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тогтоолт

Давхардсан тоогоор 2172 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, эмнэлгийн хуудсыг магадлагч эмчээр, тэтгэмж тогтоолтыг хяналт шалгалтын байцаагчаар тус тус хянуулж, баталгаажуулан 685.9 сая төгрөгийн тэтгэмж тогтоож шийдвэрлэсэн.



2.2.5.2 Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж


Тайлант хугацаанд нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлт гаргасан 123 иргэний бүрдүүлсэн баримт материалыг шалган хүлээн авч, 246.0 сая төгрөгийн тэтгэмж тогтоосон байна.

Халамжийн сангаас тэтгэмж авах эрх үүссэн 9 иргэнд нийгмийн даатгалын сангаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах эрх үүсээгүй тухай

тодорхойлолт гаргаж, гэр бүлийн гишүүнээр дамжуулан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлсэн.

2.2.5.3 Жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоолт

Цахим эмнэлгийн хуудсаар 225 даатгуулагчийн 403 цахим хүсэлтээр 1,696.6 сая төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тогтоож шийдвэрлэсэн.



- Системээс алдаа өгсөн хүсэлт – 20

Системийн алдаанаас шалтгаалж цуцалсан хүсэлтийг дахин илгээлгэх буюу өөрийн эрхээр хүсэлт үүсгэж шийдвэрлэсэн.


2.2.5.4 Ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт

Холбогдох хуульд заасан болзол нөхцөлийг хангаж, ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчийн цахим болон цаасаар гаргасан хүсэлтийг хүлээн авч ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэг бүрдүүлж ажиллалаа. Нийт 296 хүсэлтийг шийдвэрлэн, 1,539,893.4 мянган төгрөгийн тэтгэмж тогтоолоо.

157 даатгуулагчийн хүсэлт цуцалсан. Үүнд:

- Эрх үүсээгүй хүсэлт - 35
- Харъяаллын бус даатгуулагчийн хүсэлт - 25
- Ажил олгогч нь шимтгэлийн хуримтлагдсан өртэй даатгуулагчийн хүсэлт - 6
- Системээс алдаа өгсөн хүсэлт - 34
- Мэдээлэл зөрүүтэй оруулж, илгээсэн хүсэлт – 57

Харъяаллын бус даатгуулагчийн хүсэлтийг цахимаар илгээхэд тусалж, ажил олгогч нь шимтгэлийн хуримтлагдсан өртэй даатгуулагчийн хүсэлтийг өргөдөл гомдол шийдвэрлэх хуулийн хугацаанд хүлээж, шимтгэл нь төлөгдөөгүй тохиолдолд хүсэлтийг цуцлан, ажил олгогчид тогтоогдсон тэтгэмжийн дүн, тухайн тэтгэмжийг бүрэн хариуцаж даатгуулагчид төлөх хуулийн зүйл заалтыг мэдэгдэж, ажил олгогч даатгуулагч хоёрыг холбож өгч ажиллаж байна. Хүсэлт цуцалснаас хойш буюу даатгуулагчийн тэтгэмж авах хугацаа дуусахаас өмнө “Итгэлцлийн аян”-д хамрагдсан 1 ажил олгогчийн 1 даатгуулагчийн хүсэлтийг дахин авч үлдсэн хоногийн тэтгэмжийг тогтоов.



Ажлаас чөлөөлөгдөж байгаа хүний тоо 21-49 хувиар өссөн, хууль эрх зүйн орчин даатгуулагчид илүү ээлтэй байдлаар өөрчлөлт орсон нь ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн. Өмнө оны мөн үеэс 1,05%-иар буурсан нь ажилгүйдлийн тэтгэмжийн санхүүжилт хүрэлцэхгүй байгаатай холбоотой сард 2 удаа олгох сонголтоор хуваарь үүсгэж, хуваарийг сунгаж үүсгэсэнтэй холбоотой.

Ажилгүйдлийн сангийн 2025 оны төсвийн сар, улирлын хуваарь оны эхэнд 1,260.2 сая мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд 10 удаагийн өөрчлөлтөөр 1,440.6 сая төгрөг болж нэмэгдсэн хэдий ч оны туршид санхүүжилт олговол зохих тэтгэмжид хүрэлцэхгүй байдлаас даатгуулагчийн хуваарьт тэтгэмжийг 1-1.5 сараар хугацаа хэтрүүлэн олголоо. Шаардлагатай нэмэлт санхүүжилтийн тооцоолол судалгааг гарган 4 дүгээр сард СБОХХэлтэст, НДЕГ-ийн БХСГазарт 2025 оны 8 сард албан бичгээр хүргүүлж ажиллан 11, 12 сарын хуваарьт санхүүжилтийг 10 сард урагш татуулж авснаар 2025 оны 11 сарын 30-ний өдрийн байдлаар 9 дүгээр сарыг дуустал хуваарьт тэтгэмжийг бүрэн олгож дууссан, 10 сарын 08-ныг хүртлэх хуваарийг олгосон болно. 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 408 даатгуулагчийн 578.8 сая төгрөгний тэтгэмжийг олгоогүй байна.

2.2.5.4.1 Ажилгүйдлийн даатгалын сангийн олголт

/сая.төг-өөр/

Тэтгэмжийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт
Ажилгүйдлийн тэтгэмж	1,440.5	1,444.2	-3.7

Ажилгүйдлийн тэтгэмжийн мөнгөн дүн 2024 онтой харьцуулахад 8%-иар буурч, тэтгэмж авах иргэдийн тоо 16%-иар өссөн байна.

Шийдвэрлэгдсэн ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийг түүвэрлэн судлахад тус дүүргийн ажил олгогч байгууллагаас чөлөөлөгдсөн даатгуулагчийн хүсэлт 41%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний 12,75% нь төсөвт байгууллагад ажиллаж байсан иргэд байна.

2.2.5.5 YOMШӨ-ний даатгалын сангаас олгосон тэтгэмж

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 354 хүсэлт хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.

Тус сангаас 328 даатгуулагчид сэргээн засах сувиллын зардал 273.9 сая төгрөг, 8 даатгуулагчид сувилалд ирж очих унааны зардал 1.2 сая төгрөг, 3 даатгуулагчид давхардсан тоогоор 30.1 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 1 даатгуулагчид протез, ортопедийн зардлын төлбөр 1.8 сая төгрөг, 1 иргэнд нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 2.0 сая төгрөг нийт 341 иргэний 309.0 сая төгрөгийн тэтгэмж, төлбөрийг олгохоор тогтоосон байна.


YOMШӨ-ний даатгалын сангийн мэдээ

Тайлант хугацаанд тус сангаас 340 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн 309.0 сая төгрөгийн тэтгэмж, төлбөрийг олгосон байна.

/сая.төг-өөр/

	Тэтгэмжийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	33.2	30.1	3.1
2	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох	18.4	2.0	16.4
3	Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон протез, ортопедийн зардлын төлбөр	28.9	1.8	27.1
4	Сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний зардал	735.2	273.9	461.3
5	Сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардал	18.1	1.1	17.0
	Дүн	833.9	309.0	524.8

ҮОМШӨ-ний даатгалын сангийн 12 сарын тэтгэмж авсан иргэдийн тоо хэмжээ болон олгосон тэтгэврийн мөнгөн дүнг доорх графикт харуулсан байна. 2025 оны 1-р сараас эхлэн тогтмол буурч оны 6 болон 9 дүгээр саруудад нэмэгдэж 11 сарын байдлаар буурч байгаа нь байгууллагын энэ салбарт хийж буй сургалт, сурталчилгаа болон ажил олгогчийг чадавхижуулж байгаатай холбоотой гэж дүгнэлээ.




2.3 Хяналт шалгалт

2.3.1. Ажил олгогч, даатгуулагчдад хийсэн хяналт шалгалтын талаар

Тайлант хугацаанд хяналт шалгалтаар 19 ажил олгогч, 49 даатгуулагчид холбогдох ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлс, жирэмсэн амарсаны амралттай хугацаа, нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаа, хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны шимтгэл, ээлжийн амралтын олговрыг харгалзах сард нь залруулах тухай хүсэлтийг судлан, хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд шалгаж 23.4 сая төгрөгийн акт тогтоож, 18 ажил олгогчийн 23.4 сая төгрөгийг актын төлбөрийг барагдуулж, 0.014 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны эхний үлдэгдэлтэй 3 ажил олгогчийн 0.16 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг бүрэн барагдуулсан байна. Ажил олгогчид тогтоосон улсын байцаагчийн актын барагдуулалт 99.9%-тай байна.

2025 онд тогтоогдсон улсын байцаагчийн актын барагдуулалтын тоон үзүүлэлт



Өмнөх онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын, Хяналт шалгалтын газрын салбарын хяналтын улсын байцаагчийн Нүүрэнтэйн эсгий ХХК-д тогтоосон 2.0 сая төгрөгийн акт 2025 оны эхний хагас жилийн байдлаар барагдуулаагүй байна. Тус компанийн захирал болон нягтлан бодогч нартай удаа дараа холбогдоход улсын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тайлбар өгсөн байна.

2024 онд сайн дурын даатгалын шимтгэлийг гэрээний хугацаанд, хугацаа хоцроож төлсөн 574 даатгуулагч (давхардсан тоогоор)-д 13.8 сая төгрөгийн алданги тооцож бүрэн барагдуулсан боловч Сикос программд сайн дурын даатгалын алданги ногдуулалт хийх боломжгүй, программд хөгжүүлэлт хийгдээгүй байсан тул алдангийн өглөгтэй гарсан байна. Тус алдангийг хяналт шалгалтын тайлангаас хасаж, 2025 оны тайланд тусгахаар болсон. Хүснэгтээр харуулбал:

Хяналт шалгалтаар тогтоосон акт, алдангийн судалгаа

№	Тогтоогдсон актын төрөл	Оны эхний үлдэгдэл	Дт сая.төг	Кт мян.төг	Эцсийн үлдэгдэл
1	Сайн дурын даатгуулагч	0	13.8	13.8	0
	Дүн	0	13.8	13.8	0

Цалин шалгуулахаар хүсэлт гаргасан 7, мал тооллогын А дансыг шалгуулах 4, ээлжийн амралтын цалин, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг харгалзах сард нь залруулах, тайланд тусгаагүй цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нөхөн тайлагнуулах 35 өргөдлийг архивын баримт, тушаал, бусад нотлох баримтад үндэслэн тулган шалгаж, залруулах дүгнэлт гарган холбогдох санхүүгийн тасагт шилжүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйл “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах”, 15.2 дугаар зүйл “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах” заалтын дагуу дараахь зөрчлүүдийг шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж нийт 3 ажил олгогч байгууллагатай холбоотой нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын ЗНД-7, ЗНД-8 тайланг хуульд заасан хугацаанд тайлагнаагүй нөхөн тайлагнах, ажил олгогч, улсын бүртгэлийн байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах “ нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх зэрэг хэрэг материалд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж

3 ажил олгогч байгууллагатай холбоотой хэрэг материалыг хялбаршуулсан журмаар шалган хянан шийдвэрлэж, 1 сая төгрөгийн торгууль ногдууллаа.

2.3.2.Дотоод хяналт шалгалтын талаар

Дотоодын хяналт шалгалтаар тахир дутуугийн тэтгэврээс өндөр насны тэтгэвэрт шилжсэн, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь өөрчлөгдсөн, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо өөрчлөгдсөн, нөхөн даатгалын жил болон шимтгэл төлж ажилласан жил, цалин өөрчилсөн хуучин тэтгэвэртэй 591, шинээр тогтоолгосон 336, шилжиж ирсэн 8, тусгай зохицуулалт 30, нийт 965 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг материалын үндэслэл, тооцооллыг шалгалаа.

Шалгалтаар зарим саруудын цалин зөрүүтэй бичих, цалингийн орон хаях, архивын лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа, мэдээллийн бааз, нийгмийн даатгалын дэвтрүүд дээрх цалинууд зөрөх, нийгмийн даатгалын дэвтэрт цалинг баталгаажуулаагүй мөн 5 жилийн цалингийн тодорхойлолтыг хяналтаар баталгаажуулаагүй, хөдөлмөрийн дэвтэр болон иргэний үнэмлэхний овог ондоо байх, шимтгэл төлөлтийн архивын лавлагаа дутуу, байгууллагын нэр өөрчилсөн лавлагаа дутуу, ээлжийн амралтын хязгаарлагдаагүй хөдөлмөрийн хөлсийг хуваагаагүй, Засгийн газрын тогтоолоор нэмэгдсэн тэтгэврийн нэмэгдлийг хувийн хэрэгт тэмдэглээгүй, ажилласан жил зөрүүтэй оруулах зэрэг 187 тэтгэврийн материалын зөрчлийг илрүүлэн, залруулж, алдааг давтан гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх талаар байцаагч мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгөв.

Шалгасан тэтгэврийн төрөл, хөдөлгөөн, тэтгэвэр авагчийн хүйсийн тоон үзүүлэлт:

№	Тэтгэврийн төлөв	Тэтгэврийн төрөл	Тоо хэмжээ
1	Нийт 965 тэтгэвэр -Үүнээс:	Өндөр насны тэтгэвэр	462
		Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	419
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	84
2	Нийт 965 тэтгэвэр - Үүнээс:	Шинэ	336
		Хуучин	591
		Шилжиж ирсэн	8
		Тусгай зохицуулалт	30
3	Нийт 965 тэтгэвэр - Үүнээс:	Эр	560
		Эм	405

Улсын байцаагчийн актаар тогтоогдсон 10 тэтгэвэр авагчтай холбоотой төлбөрийн оны эхний үлдэгдэл 98761.4 мянган төгрөгийн төлбөрөөс тайлант хугацаанд барагдуулаагүй байна.

2025 оны эхний үлдэгдэлтэй хуурамч бичиг баримтаар тэтгэвэр тогтоолгосон 20 тэтгэвэр авагчийн 409.8 сая төгрөгийн актын төлбөрөөс барагдуулаагүй, 409.8 сая төгрөг үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд тэтгэвэр авагч 5 хүнд илүү, дутуу олгосон 24.3 сая төгрөгийн тэтгэвэрт акт тогтоогдож, 20.4 сая төгрөгийг барагдуулсан байна. Тэтгэвэр авагч 1 хүнд илүү олгосон 4.4 сая төгрөгийг 2025 оны 07 дугаар сараас төлж эхлэхээр төлөлтийн хуваарь байгуулан 0.5 сая төгрөгийг барагдуулж, 3.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Улсын байцаагчийн актын барагдуулалт 84%-тай байна.

Даатгуулагч эхийн 2022 оны жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн актын төлбөрийн 1 сая төгрөг барагдаагүй үлдэгдэлтэй байна.


Ажилгүйдлийн тэтгэмж авахаар өргөдөл хүсэлт гаргасан 369 даатгуулагчдын хувийн хэрэг материалын тэтгэмжийн бодолт, баримт материалын бүрдэлт, хуулийн хугацаа зэргийг шалгасан.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж: 156 байгууллагын 2536 даатгуулагч, сайн дурын 185 даатгуулагчдын эмнэлгийн хуудсыг зохих журмын дагуу хянаж, шалгав. Үүнд:

№	Байгууллага	Тэтгэмжийн төрөл	Тоо хэмжээ
1	Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч – 185	ЖАТ	64
		ХЧТА	121
		Эр	39
		Эм	146
2	156 ажил олгогч байгууллагын тэтгэмж авсан даатгуулагч 2541	ЖАТ	360
		ХЧТА	2172
		ҮОМШӨ ХЧТА	9
		Нийт дүн	2726

Гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмжийг 123 иргэнд, сувиллын зардал 319 даатгуулагчид, ҮОМШӨ сувилалд ирж очих унааны зардал авах 8, бааз хөрвүүлэх 28 хүсэлтийг сикос программ, нэгдсэн лавлагаатай тулган шалгав.

Тэтгэвэр, тэтгэмж, сувиллын зардал шалгасан тоон үзүүлэлт



2.3.3. Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хийсэн хяналт шалгалт

2.3.3.1. “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 13-07/06 дугаартай “ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамж”-ийн дагуу тус нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгаалалын хяналтын улсын ахлах байцаагч Б.Хишигжаргал ахалж, Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Г.Бямбажаргал,

О.Пүрэвжав нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд ирж ажиллалаа.

Шалгалтаар Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, нягтлан бодох бүртгэл, цалин хөлс, санхүүгийн анхан шатны баримт, аж ахуйн нэгж, байгууллагын тушаал шийдвэр, иргэн болон ажилтантай байгуулсан холбогдох гэрээнд тулгуурлан шалгаж, улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэсэн бөгөөд актын зарим хэсэгтэй тус газрын зүгээс санал нийлэхгүй тул шийдвэрийг эцэслээгүй байна.

2.3.3.2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “аж ахуйн нэгж, Байгууллагад нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн дагуу тус газрын Захиргаа хяналтын хэлтсийн дарга, Нийгмийн даатгалын улсын байцаагч Г.Батболд, хяналт шалгалтын байцаагч, Нийгмийн даатгалын улсын байцаагч Х.Тогтвор нар ерөнхий боловсролын Сод сургуулийн 2020-2024 оны санхүүгийн болон холбогдох бусад баримтад үндэслэн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж зөвлөмж хүргүүлсэн байна.

2.3.3.3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 01/2065 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу тус газрын Захиргаа хяналтын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч Х.Тогтвор 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг дуусталх хугацаанд тус газарт ажил олгогчийн ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД-7), нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлан (НД-8)-д 2024-2025 онд нөхөн тайлагнасан, цалин хөлсний хэмжээг өөрчилсөн, устгасан, даатгуулагчийн регистр зэрэг үндсэн мэдээллийг засварласан, нэгтгэсэн байдлыг санхүүгийн болон холбогдох нотлох баримтад үндэслэн Нийгмийн ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын хэрэгжилтийг шалгаж тайланг хүргүүлсэн байна.

2.3.3.4.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “аж ахуйн нэгж, Байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн дагуу жагсаалтаар ирүүлсэн 20 аж ахуйн нэгж, байгууллагаас 4 байгууллагын үйл ажиллагаа 2020 оноос өмнө зогссон төлөвтэй, тайлан ирүүлээгүй, 1 аж ахуйн нэгж тус газрын удирдах албан тушаалтны хамаарал бүхий компани учир шалгахгаас татгалзаад байна. Дээрх 15 байгууллагаас гадна хяналт шалгалтад хамруулах аж ахуйн нэгжийн жагсаалтад тусгагдаагүй нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 6 байгууллагад удирдамж хүргүүлж, нийт 21 байгууллагаас 16 нь шалгуулахаар санхүүгийн анхан шатны баримт, тушаал шийдвэр, иргэн болон ажилтантай байгуулсан холбогдох гэрээ ирүүлсэн байна.

2.3.3.5.Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 07/2963 дугаартай “Шийдвэр хүргүүлэх тухай” албан бичиг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/306 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” тушаалын дагуу 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд тус газарт ажил олгогчийн ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД-7), нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлан (НД-8)-д 2024-2025 онд нөхөн тайлагнасан, цалин хөлсний хэмжээг өөрчилсөн, устгасан, даатгуулагчийн регистр зэрэг үндсэн мэдээллийг засварласан, нэгтгэсэн байдлыг санхүүгийн болон холбогдох нотлох баримтад үндэслэн Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийгмийн ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын хэрэгжилтийг шалгаж, тайланг хүргүүлсэн байна.

2.3.4. Шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн шалгалтын талаар

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгавраар өгөгдсөн үүрэг даалгавартай холбогдуулан шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2025 оны 01 дүгээр улирлын мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудит мониторингийн газраас 2025 оны 01-03 дугаар сарын шилэн дансыг шалгасан байна. Зөвлөмж хүргүүлж, зөрчлийг арилган, биелэлтийг тайлагнасан байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврыг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02/529 дүгээр албан бичгээр, Шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээний танилцуулгыг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/1090 дүгээр албан бичгээр, мөн шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай 02/262 дугаар албан бичгээр ирүүлсэнийг мөрдөн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 02/1583 дугаартай “Ажил зохион байгуулах” тухай албан бичгийн дагуу тус газрын 2025 оны 01-06 дугаар сарын Шилэн дансны цахим хуудасны хөтлөлт, мэдээлэл байршуулалт, холбогдох шийдвэр, баримт бичгийг shilendans.gov.mn вэб сайтад бүрэн оруулсан эсэхийг шалгаж нягтлан бодогч нарт анхаарах асуудал, гарсан зөрчлийг арилгуулах талаар зөвлөгөө өгч тайланг Дотоод аудитын мониторингийн газарт хүргүүлсэн байна. Мөн Шилэн дансны тухай хууль, анхаарах асуудлын талаар сургалтыг Багануур дүүргийн Дотоод аудитын албанаас нийт албан хаагч нарт авсан байна.

2.4 Архив

2.4.1 Архивын дотоод зохион байгуулалт, үйл ажиллгаа

Тус газрын 2025 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад оруулах саналыг хэлтсийн дарга нараар дамжуулан, нийт ажилтнуудаас авч, боловсруулан, хөтлөх хэргийн жагсаалтыг батлуулсан. Үүнд:

Цаасан суурьтай баримт	Цахимжуулсан баримт
Байнга хадгалах -43	Байнга хадгалах -42
70 жил хадгалах -16	70 жил хадгалах -14
Түр хадгалах - 70	Түр хадгалах -72

Тайлангийн хугацаанд байгууллагын 2024 оны үйл ажиллагааны явцад бүрдүүлсэн баримтыг архивт 2025 оны 01 дүгээр улиралд хүлээн авах хуваарийг батлуулж, албан хаагчдын ажлын ачааллаас шалтгаалан мөн оны 02, 03 дугаар улиралд зохих журмын дагуу хүлээн авсан. Үүнд:

Өндөр насны тэтгэврийн 91, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн 123, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 11 зогсоогдсон хувийн хэргийг, 2017-2023 оны цаасан суурьтай 57, 2024 оны 92 баримт, сайн дурын даатгуулагчийн 92 хувийн хэрэг, цахимжуулсан 75 баримтыг нэг бүрчлэн шалгаж, актаар хүлээн авав.


Дээрх баримтыг хүлээн авсан бүртгэл үйлдэн, он цагийн хязгаараар байршуулж, байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчилж, цахим хадгаламжийн нэгжийг шинээр бүртгэлжүүлэв.

Тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/13 дугаар тушаалаар байгуулагдсан архивын хадгаламжийн нэгжид тооллого явуулах комисс нь 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс мөн оны 06 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд 13367 хадгаламжийн нэгжийг тоолж, баталгааны хуудсанд “Тоолов” тэмдэглэл, тооллого явуулсан огноо, ажилтны албан тушаалыг тэмдэглэж, гарын үсгээр баталгаажуулсан.

Тооллого явуулсан талаарх илтгэх хуудсыг бичиж, нийт албан хаагчдад танилцуулсан ба газрын дэргэдэх БНШК-ын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, дутагдсан хадгаламжийн нэгж, хувийн хэргийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, албан хаагчдад танилцуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тооллогоор архивын сан хөмрөгт байгаа хадгаламжийн нэгжийг данс бүртгэлээр нэг бүрчлэн тулгахад хадгалах хугацаа дууссан 311, дутагдсан 17 хадгаламжийн нэгж, 72 хувийн хэрэг, 2 иргэний нөхөн даатгалын материал, сэлбэн засварлах 23, данс бүртгэл солих 12, баримтын бүрдэл дутуу 455, данс бүртгэлд тэмдэглэсэн жагсаалтын зүйлийн дугаар, хадгалах хугацаа хадгаламжийн нэгжийнхээс зөрүүтэй 33, хөгцөрч гэмтсэн 1, он цагийн хязгаар зөрчиж, 2-оос дээш оны материалыг хамтад нь үдсэн 17 хадгаламжийн нэгж байгаа зөрчил илэрсэн.

Тооллогоор илэрсэн зөрчлийг арилгаж 2-оос дээш оны материалыг хамтад нь үдсэн 17 хадгаламжийн нэгжийг задалж, 2005-2018 оны 54 хадгаламжийн нэгж үүсгэсэн.



Комиссын зарим гишүүд тоологын үеэр...

Чийг, дулаан хэмжигч шинээр худалдан авч, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторт 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулж, гэрчилгээжүүлэв.

Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журамд заасны дагуу чийг дулааныг 7 хоногт 3-аас доошгүй удаа хэмжин, тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, цэвэрлэгээг 7 хоног бүр хийлгэж байна.

Архивын өрөөний чийг, дулаан журамд зааснаар цаасан суурьтай баримт (+14)-өөс (+16) градус, харьцангуй чийгшил 50-55%-тай байхаас халаалттай үед 40%-аас дээш гарахгүй байгаагаас баримтын хадгалалтын горим алдагдаж, чанар байдлаа алдах эрсдэлтэй тул агаар чийгшүүлэгч шинээр авсан ба өдөрт зохистой хэмжээгээр ажиллуулж байна.



Мөн тасгаас ирүүлсэн албан бичгийн хүрээнд 2023, 2024 оны цалингийн тооцооны хүснэгтийг цахим хэлбэрт шилжүүлэн, 2025 оны 06 дугаар сард хянуулан, алдааг засч, хүлээлгэн өгсөн.

Газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссыг 3 удаа хуралдуулж, 7 асуудлыг тус тус хэлэлцүүлэн, тэмдэглэл хөтөлж, хэрэгжилтийг ханган баримтжуулсан.

Архиваас албан хаагчдад түр ашиглуулахаар 61 удаа 195 хадгаламжийн нэгжийг өгч, бүртгэл хөтөлж, хадгаламжийн нэгжийн ашиглалтын хуудасны тэмдэглэлийг хянав.

Тайлангийн хугацаанд утсанд (CallPro) 220 дуудлага ирснээс 212 дуудлагыг хүлээн авч, мэдээлэл зөвлөгөө өгч, 8 дуудлагад хариу өгөөгүй ба дуудлага алдалт 4.5% байна.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн Улсын үзлэг зохион байгуулах 23 дугаар “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг” тухай тогтоолоор 2025 оны 10 дугаар сарын 29-нд тус газар шалгуулж 94.5% -иар үнэлүүллээ.

2.4.2 Иргэдээс архивт ирүүлсэн хүсэлт

2025 онд шийдвэрлэсэн лавлагааны хүсэлтийг 2024 оны мөн үетэй харьцуулбал 14.9%-р буурсан байна.

Д/д	Лавлагааны төрөл	Огноо		Үзүүлэлт	
		2024 он	2025 он	Тоо	Хувь
1	Метадата	300	301	+1	+0,3%
2	Явуулсан	182	169	-23	-11,9%
3	Ирсэн	70	69	-1	-1,4%
4	Цахим	363	248	-115	-31,6%
Нийт		925	925	138	-14,9%

Архивчдын хөгжил сургалт, арга зүйн төвөөс зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтад 2025 оны 10 дугаар сарын 13-24 хүртэл 14 өдрийн хугацаанд цахимаар оролцож, сертификат гардан авч мэргэжлийн Архивийн үйлчилгээ үзүүлэхээр зорьж байна.

2.5 Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл

Төв болон салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ажил олгогч, даатгуулагчийн болон нийгмийн даатгалын байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, ажил олгогч, даатгуулагчийн нууцыг чанд хадгалах зарчмыг баримталж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийг удирдлага болгон ажиллаж байна.

Албан тушаалын нэршил өөрчилсөнтэй холбоотойгоор тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга, гишүүдээр Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга, Захиргаа, хяналтын хэлтсийн дарга, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга, орлого шимтгэлийн байцаагч, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн хэлтсийн дарга болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нар, дүүргийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч гишүүн, Багануур ХК-ийн хуулийн зөвлөх, нарийн бичгийн даргаар тус газрын хяналт шалгалтын байцаагч нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Тайлант хугацаанд салбар зөвлөл нь 5 удаагийн хурлаар ажлын байрны хортой нөхцөлөөр 1, хүнд нөхцөлөөр 2, өөрчлөн тогтоосон тэтгэвэрийн олгож эхлэх хугацааг тогтоолгох 2, ажилгүйдлийн тэтгэмж олгож эхлэх өдрийг тогтоох тухай 2, малчнаар ажилласанд тооцуулах тухай 1 нийт 8 даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 7 даатгуулагчийн хүсэлтийг ханган шийдвэрлэж, 1 даатгуулагчийг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласнаар тооцох боломжгүй талаар хурладаанаар шийдвэрлэлээ.

2.5.1 Маргаан хянан шийдвэрлэлтийн талаар

Өргөдлийн төрөл	Өргөдлийн тоо	Хэрхэн шийдвэрлэсэн
Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилласнаар тооцохгүй тухай	1	Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ын “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-ын - Хоёр. “Хөдөлмөрийн хортой нөхцөл”-ийн 2.19 дэх хэсгийн “Нефть боловсруулах үйлдвэр”-ийн 200 дахь заалтын 9333-15 кодтой шатахуун ачигч, шатахуун буулгагч ажлын байрт дүйцүүлж, хөдөлмөрийн хортой нөхцөлд хамааруулан тооцохгүй болохыг тогтоосон.

Хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласнаар тооцсон тухай	2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг заасан жишээ-2 баримтлан Дөрөв. “Хөдөлмөрийн хүнд нөхцөл”-ийн 31 дэх хэсгийн “Нийслэлийн нийтийн тээврийн том оврын зорчигч тээвэр”-ийн 1-т заасан 8331-11 кодтой ажил, мэргэжилд хамааруулан хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласнаар тооцсон.
Тэтгэвэр олгож эхлэх хугацааг тогтоох тухай	2	Цэргийн алба хаасны тэтгэврийг өөрчлөн тогтоолгох зорилгоор, 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр тус газарт тэтгэвэр тогтоолгосон хугацаанд хамаарах 2005 оны 02, 03 дугаар сарын цалинг залруулах хүсэлт ирүүлсэнийг харгалзан, өмнө авч байсан тэтгэвэр, өөрчлөн тогтоосон тэтгэврийн зөрүүг тооцож, 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс нөхөн олгох. Өндөр насны тэтгэврийг өөрчлөн тогтоолгох зорилгоор тэтгэвэр тогтоолгосон хугацаанд хамаарах 1995 оны 12 сар, 1998 оны 7, 9, 11, 12 сар, 2000 оны 12 сар, 2001 оны 1, 3, 4-10 дугаар саруудын цалинг нөхөн төлүүлэх хүсэлтийг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр тус газарт ирүүлснийг харгалзан өмнө авч байсан тэтгэвэр, өөрчлөн тогтоосон тэтгэврийн зөрүүг тооцож, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн олгох.
Ажилгүйдлийн тэтгэмжийг олгож эхлэх өдрийг тогтоох тухай	2	Даатгуулагч нь 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр ажлаас чөлөөлөгдөж, 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Нийгмийн даатгалд цахимаар ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан байна. Тухайн үед Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн цахим системд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөр бүртгэлтэй байсан хугацаагаар программд алдаатай хүсэлт илгээгдэж, тэтгэмжийн байцаагч энэ талаар даатгуулагчид мэдэгдсэнээр, даатгуулагч тус хэлтсийн цахим системд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр дахин бүртгүүлсэн байна. Даатгуулагч өөрөөс үл хамаарах шалтгаанаар хугацаа хойшилж бүртгүүлсэнийг харгалзан, даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад тэтгэмж авах хүсэлт илгээсэн өдөр буюу 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс тогтоон олгох. Даатгуулагч нь 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ажлаас чөлөөлөгдөж, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Нийгмийн даатгалд цахимаар ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан байна. Тухайн үед Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн цахим системд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр бүртгэлтэй байсан хугацаагаар программд алдаатай

		хүсэлт илгээгдэж, тэтгэмжийн байцаагч энэ талаар даатгуулагчид мэдэгдсэнээр, даатгуулагч тус хэлтсийн цахим системд 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр дахин бүртгүүлсэн байна. Даатгуулагч өөрөөс үл хамаарах шалтгаанаар хугацаа хойшилж бүртгүүлсэнийг харгалзан, Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад тэтгэмж авах хүсэлт илгээсэн өдөр буюу 2025 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс тогтоон олгосугай.
Малчнаар ажилласанд тооцох тухай	1	Даатгуулагч нь нөхөртэйгээ 1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр гэрлэлтээ батлуулсан, 1995 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүүхэд төрүүлж, эцгээр нь овоглосон тул 1995 оны 03 дугаар сараас малчнаар ажилласанд тооцсон.

2.6 Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөл

2.6.1 Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн үйл ажиллагаа

Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурал долоо хоног бүрийн Лхагва гарагт Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэйгээр, нийт 35 удаа 77 цаг хуралдлаа.

Тайлант хугацаанд зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдтэй холбоотой гомдол, зөрчил гараагүй.

Хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг шинээр 67 иргэнд тогтоож,

52 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг цуцалж,

392 иргэнийг магадлан сунгаж, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цаг богиносгосон шийдвэр 1,

үйлдвэрлэлийн ослын улмаас 3 хүртэлх сараар нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд байж, эмнэлгийн хуудас авсан гэх заалтаар 1 нийт 511 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны шийдвэр гаргасан.

2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 878 иргэн тэтгэвэр тогтоолгон авч байна.Үүнд

Нийгмийн даатгалын сангаас -577 иргэн

Нийгмийн халамжийн сангаас - 311 иргэн тэтгэвэр авч байна.

Хөдөлмөрийн чадвараа алдалтын хувь:

1. 50-69%-аар алдсан 453 иргэн
2. 70-100%-аар алдсан 425 иргэн байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг сэтгэцийн эмгэг, дотрын өвчин, мэдрэлийн эмгэг, нүд, гэмтлийн эмгэгүүд эхний 5 байр буюу нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 80 хувийг эзэлж байгаа ба хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 70 гаруй хувь нь 31-59 насны хөдөлмөрийн насны иргэд байна.



Үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр авагч 24 даатгуулагч байдаг ба шинээр үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдоогүй.

Шинэчилж батлагдсан “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт”-ыг хэрэгжүүлэн ажиллахад хувь буурсан 43, хувь өссөн 24 иргэн байна. Шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг тогтоолгож буй иргэний оношийг магадлах, биеийн байдлыг үнэлэх, мэдээлэл солилцох, цаашид тусламж үйлчилгээ, хяналтыг зөв чиглүүлэх, эмчлэн эрүүлжих зөвлөгөө өгөхөөр иргэнийг биеэр хуралд оролцуулж, хүнд өвчтэй иргэнийг цахимаар болон гэрээр очиж үзэж хяналт тавьж байна.

Ижил мэргэжилтний үзлэгийг 2-р улиралд Багануур, Налайх, Дорноговь, Булган аймагтай, 3-р улиралд Баянзүрх, Говьсүмбэр аймгуудтай хамтран зохион байгуулсан. Үзлэгийн үр дүнд туршлага солилцон, дотоодын хяналтыг сайжруулах мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн ажиллав.

Дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдах үндэслэлд хяналт хийх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах арга замыг судлах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2025 оны А/152 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэний заалтын үндэслэл, явцын хяналт, эмнэлгийн анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт, эмх цэгцэд хяналт, үнэлгээ хийж хороодоор ажиллан 300 гаруй иргэдийг дахин магадлав.



Хороодоор хяналт, шалгалтын үр дүнд дахин магадлал хийж, зөвлөлийн хурлаар хугацаагүй шийдвэртэй 93 иргэнийг дахин магадлахад 19 иргэний хугацаа өөрчлөгдсөн, 4 иргэний /хавдарын заалттай/ хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалсан байна.



Дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, түүнд зонхилох өвчин, шалтгаан зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор дүүргийн ИТХ-н төлөөлөгчид, дүүргийн Засаг дарга, холбогдох удирдлагууд, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт нээлттэй мэдээлэл хийж 37 албан хаагчдыг хамруулав.

Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмын дагуу сонгон шалгаруулалт 2025 онд зохион байгуулагдаж Улаанбаатар хотын “Сэргээн засах клиник эмнэлэг” ХХК, Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн “Ургамал сувилал”, “Альфамедикал центр” ХХК, “Хос шинэс” ХХК, Төв аймгийн “Си Си хатан” ХХК, Хөвсгөл аймгийн “Галт халуун рашаан” ХХК, Өвөрхангай аймгийн “Ананд хужирт” ХХК тус тус шалгарч Нийгмийн даатгалын ерөнхий газар нь нийт 11 сувилалтай “Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г нэг жилийн хугацаатай байгуулсан. 2024 онд сонгон шалгаруулалтад тэнцсэн Багануур сувилал ХХК-тай хамтран ажиллах гэрээг сунгаж байгуулсан.

Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн хяналтаар нийгмийн даатгалын сангаас 483, нийгмийн халамжийн сангаас 320, даатгуулагч хүний мэдээллийг тулгахад нас барсан 3, сан хооронд шилжсэн 2, өвчний ангилал нь заалттай зөрсөн 1, өвчний шалтгаан нь оноштой зөрсөн 2 иргэний мэдээллийг засаж бүртгэлээ.


2025 оны 11 сарын 12-ны өдрөөс ЭММЗ-ийн программыг сикос системд холбосноор даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон, сунгасан, цуцалсан шийдвэр бүрэн цахимжиж, цаасан акт ашиглахгүй болж, тэтгэврийн дэд системд мэдээлэл шууд татагдаж, тэтгэврийн өөрчлөн тогтоолтыг хийх, даатгуулагч иргэн шинээр хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр тогтоолгох хүсэлт цахимаар илгээх боломжтой боллоо.

2.6.2 Эрүүл мэндийн байгууллага, сувиллын үйл ажиллагааны хяналт, эмнэлгийн хуудасны бичилт, олголт, хяналт

Тус дүүргийн Эрүүл мэндийн төв нь medsoft программ ашиглаж цахимд шилжин цаасгүй эмнэлэг болсон. Иргэний эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээний дүгнэлт нь цахимд бичигдэж иргэн өөрөө цахим хуудаснаас хэвлэх, эмнэлгийн цахим бүртгэлээс хэвлүүлэн авч амбулаторийн картад хавсарган наадаг бөгөөд энэ нь эмх, цэгцтэй, хаяж үрэгдүүлэхэд дахин хэвлээд авах боломжтой юм. Төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн үечилсэн дүгнэлтийн бичилт, өвчтөнг хянах хяналтын карт, өвчтөн хөтлөх уналт таталтын карт, оношийн баталгаажилтанд 4-өөс дээш удаа дотоодын хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилган арга хэмжээ авч ажилласан.

ЭММЗ-ийн хурлаар орж буй иргэдийн амбулатори, хяналтын картыг сайжруулах аян зохион байгуулж, үүний үр дүнд эмэгтэйчүүд, чих хамар хоолой, нүд, сэтгэц, дотрын амбулаторийн карт, өрхийн эмнэлгүүдийн хяналтын картны эмх цэгц сайжирсан байна.

Дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, түүнд зонхилох өвчин, шалтгаан зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор дүүргийн ИТХ-н төлөөлөгчид, дүүргийн Засаг дарга, холбогдох удирдлагууд, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт нээлттэй мэдээлэл хийж 37 албан хаагчдыг хамруулав. ЭММЗ-ийн гарын авлага хэвлэгдээгүй тул цахимаас татаж авч олшруулан зөвлөлийн гишүүд, амбулаторийн эмч, өрхийн



эмнэлгүүдэд нийт 17 хувь, ердийн өвчний жагсаалтын заавар номыг хувилж гарын авлагаар хангасан.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтанд гишүүд хамрагдлаа.



Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн хуудас олгодог, баталдаг эмч, бүртгэл хариуцсан сувилагч, баталгаажуулж иргэний хурууны хээг уншуулдаг, илгээдэг дүн бүртгэлийн бага эмч зэрэг эмч мэргэжилтнүүдэд цахим болон танхимаар нийт 3 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 5 эмнэлгийн 200 гаруй эмч мэргэжилтэнг хамруулсан. Эмнэлгийн хуудас олголт, бичилт, сикос программын үйлдэлийн дараалал, иргэн цахимаар хүсэлт гаргах зааварчилгаа, хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, илгээгдсэн эмнэлгийн хуудасны алдаа зөрчлийн талаар

сургалт зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлсэн, зөрчил гарах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллав.

Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа “Багануур сувилал” ХХК-ний даатгуулагчид үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж, жилийн гэрээ дүгнэхдээ үр дүнг тооцон ажиллаж, цаг үеийн мэдээллээр хангаж ажилладаг.


Сувилалын тусламж үйлчилгээний нэхэмжлэхийн дагуу 11 сарын байдлаар тус сувиллын 1-10 сард тусламж, үйлчилгээ авсан 327 даатгуулагчийн 3907 ор, хоногийн тусламж, үйлчилгээ авсан сувилуулагчийн түүх, илгээх бичиг зэрэг баримтыг хянаж баталгаажуулав.



Тус сувилал нь 2025 онд Сэргээн засах эмчилгээний 7 төрлийн тоног төхөөрөмж, 3 төрлийн эмчилгээг нэмсэн, стандарт, эмнэлзүйн удирдамжийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлээгүйгээс үйлчлүүлэгч хохирсон тохиолдол гараагүй байна. Ижил мэргэжилтний үнэлгээг 2 сар тутамд хийж эмч мэргэжилтний мэдлэгийг бататган ажилласан


байна.

Сувиллын зуны үйлчлүүлэгч хүлээн авах, эмчийн үзлэгийн явц /2025.07.21/



Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/13 тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу 1020 үйлчлүүлэгчийг 4 бүлэг 18 асуумжтай судалгаанд хамруулан, дүгнэж, санал хүсэлтийн дагуу цаг тухай бүр үйлчилгээг сайжруулан, мэдээлэл тайлбар өгч шийдвэрлэн ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 хамтарсан тушаалаар батлагдсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох” журмыг баримтлан ажиллаж байна. Газрын даргын 2025 оны 01 сарын 30-ны өдрийн 20 дугаар албан тоотоор тус журмын 4.9, 5.3 дахь заалтыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагын *эмнэлгийн хуудас олголтын жагсаалтад цахим хяналт*, дүгнэлт хийж ажилласан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон хувийн хэвшлийн эмнэлгүүд 297 эмнэлгийн хуудас бичиж олгожээ.




Эрүүл мэндийн төвөөс 2409 хөдөлмөрийн чадвар түр алдсны, жирэмсэний болон амаржсны 410 эмнэлгийн хуудас олгосон байна.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчид олгосон эмнэлгийн хуудасны оношийн үндэслэлд хяналт хийж эмчийн үзлэг, шинжилгээний дүгнэлтийг татаж хянасан.

Дүүргийн 5 хорооны 3 өрхийн эрүүл мэндийн төв, 1 хувийн хэвшил, эрүүл мэндийн төв, эмнэлгийн жирэмсний зөвлөгөө өгөх кабинетад эмнэлгийн хуудас бичилт, олголтын үндэслэлд 5 удаагийн хяналт хийж, холбогдох дүрэм журмын мэдээллийг өгч, цахим архив үүсгэн хадгалж ажиллахыг анхааруулан ажилласан. Мөн зөрчилтэй эмнэлгийн хуудас бичиж олгосон эмч болон тухайн эмнэлгийн мэдээллийн ажилтантай уулзаж программд хяналт хийж, эмчид арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2025 оны 10 сарын 05-наас эмнэлгийн хуудасны хяналтыг Сүхбаатар дүүрэг, Багануур дүүрэг, Сэлэнгэ аймаг, Завхан аймгуудын эрхийг нэгтгэн хяналт хийгдэж байна. НДЕГ-ын Мэдээлэл технологийн төвөөс нэгтгэн гаргасан дүгнэлтээр тус дүүргийн магадлагч эмчийн эмнэлгийн хуудасны хяналтын хугацаа дундажаар 2 хүртэлх хоног байна.



ГУРАВ. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

Нийгмийн даатгалын үйлчилгээг илүү хүртээмжтэй хүргэх үүднээс хяналтын байцаагч нарын өрөөг сольж 1 давхарт шилжүүлэн, иргэдэд аль болох ойлгомжтой байдал аар өрөө тасалгааны зохион байгуулалтыг хийсэн.

Үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд Багануур дүүргийн Насан туршийн боловсролын төвөөс “Харилцаа, хандлага” сэдэвт сургалтад нийт 20 албан хаагчид оролцсон.

Иргэн төвт зорилгын хүрээнд цахим үйлчилгээг аль болох сурталчлан таниулах, иргэдийг цахим үйлчилгээ авах боломжоор хангах, цахим үйлчилгээг хэрхэн авах, хэрхэн ашиглах талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах үүргийг албан хаагч бүрд өгч, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Callpro утсаар мэдээлэл, зөвлөгөө хүргэх

Тус газар нь тайлант хугацаанд нийт 5,874 дуудлагаас 5477 дуудлага хүлээн авч, нийт дуудлагын 6.75%-ийг алдсан



ДӨРӨВ. ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АЖЛЫН БИЕЛЭЛТ

НДЕГ-ын удирдах ажилтны зөвлөгөөн, Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан 14 хоног тутамд зохион байгуулагддаг. Тус газрын удирдлага шуурхай хуралдаанд тогтмол оролцож, хуралдсан тухайн өдөрт багтаан бүх ажилтны хурал зарлаж, цаг үеийн мэдээллээр албан хаагчдыг тогтмол хангаж ажилладаг. Удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжүүлж, тус газраас нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цаг үеийн шинжтэй хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Лхагва гарагт улсын хэмжээнд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор аюулгүйн талбайд 13 хүн цугларч, 4 хүн сургалтад оролцож, цугларах нэгдсэн дадлага сургууль хийсэн илтгэх хуудсыг мэйл болон албан бичгээр илгээсэн.

Дүүргийн засаг даргын тамгын газар, Монгол улсын Ёс зүй хороотой хамтран хийсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаарх сургалтад нийт 18 албан хаагч оролцож 2025 оныг ёс зүйтэй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах зорилго тавин өөрсдийн зүгээс нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, нийгмийн сайн сайхан зүйлсийн нэг хэсэг байна гэдэгтэй итгэлтэй байна.

Сайн дураар даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тус газрын 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн “Хамтран ажиллах тухай” 48 тоот албан бичгээр дүүргийн хороод руу малчин мал бүхий, эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эцгийн судалгааны хүснэгтийг хүргүүлэн, хариуг авч нэгтгэв.

Судалгааг нэгтгэхэд малчин мал бүхий 997, эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг 77 иргэн байна. Малчин сайн дураар даатгуулах боломжтой 427 иргэнээс 170, эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг 64 иргэнээс 36 хамруулсан байна.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан 14 хоног тутамд зохион байгуулагддаг. Тус газрын удирдлага шуурхай хуралдаанд тогтмол оролцож, хуралдсан тухайн өдөрт багтаан бүх ажилтны хурал зарлаж, цаг үеийн мэдээллээр албан хаагчдыг тогтмол хангаж ажилладаг. Удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжүүлж, тус газраас нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цаг үеийн шинжтэй хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 1 удаагийн мэдээлэл хийсэн.



Тус газрын дарга Р.Өнөржаргал Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас 2025 онд зохион байгуулсан Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдан амжилттай суралцаж, 2025 оны 06 дугаар сард сертификат гардан авлаа.

Тус газар нь Нийгмийн даатгалын байгууллагын 83 жилийн ойн хүрээнд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан Монгол бичгийн уралдаанд тус газрын Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтэн М.Мөнхчимэг тэргүүн байр, Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулсан Боулингийн тэмцээний гутгаар байранд тус тус шалгарсан.

Тус үйл ажиллагаанд 9 дүүргийн Нийгмийн даатгалын газрын 60 гаруй албан хаагч оролцсон.



Багануур дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн, эрүүл мэнд” сэдэвт биеийн тамир, спортын IX их наадам 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд 85 байгууллага, аж ахуйн нэгжийн 16 баг тамирчдын дунд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, дартс, шатар, 100 буудалт даам, боулинг, коран хол, олс таталт, хөнгөн атлетик, ширээний шагай, спорт явган аяллын нийт 12 төрлөөр амжилттай зохиогдож өндөрлөлөө.

Тус наадамд дүүргийн ИТХ, ЗДТГ, түүний дэргэдэх газар, хэлтэс хамтарсан “Төрийн захиргаа” баг бүх төрөлд амжилттай оролцож тус газрын Г.Батболд, Т.Ганчимэг нар сагсан бөмбөг 40+ ангилалд, Г.Батболд волейболын төрөлд 40+ ангилалд, Б.Сүхболд хөнгөн атлетикийн 4х100м буухиа төрөлд, Б.Наранцэцэг ширээний шагайн 40+ ангилалд, Б.Балжинням эмэгтэй шатар төрөлд хамт олноо төлөөлөн өрсөлдөв.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд Монгол Улсад жил бүр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян” өрнүүлж аяны хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, сургалт сурталчилгаа хийх олон хэлбэрийн арга хэмжээг зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 04/1395 дугаар бичгийн хүрээнд Хүүхэд, залуучуудын хүмүүжлийн тусгай цогцолборт хүмүүжиж буй эгч дүү гурав хүүхдэд газрын хамт олноос 0.1 сая Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 03/2787 бичгийн хүрээнд Төв аймгийн нийгмийн даатгалын газрын хяналт, шалгалтын улсын байцаагч Осорын Энхтуяад 0.2 сая төгрөгийг тус тус хандивлав.

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ЗӨРЧИЛГҮЙ, ТӨСВИЙН ӨР АВЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

6.1 Байгууллагын нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын талаар

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь НББОУС, УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруз сууриар IT zone ХХК-ийн “Green ERP” программ ашиглан бүртгэлийг хөтөлж, “Төсвийн тухай” хуулийн 54 дүгээр зүйлийн дагуу 2025 оны эхний улирлын санхүүгийн тайланг бэлтгэн, хуульд заасан хугацаанд, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж, НДЕГ-т хүргүүлэв. Үүнээс гадна сар бүрийн мэдээг НДЕГ-т хүргүүлж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав.

Өдөр тутмын санхүүгийн гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем <https://finance.gov.mn>, алба хаагчдын цалин хөлсийг төрийн албаны цалингийн нэгдсэн систем <https://payroll.gov.mn/> -ээр тооцож, НДШ, ХХОАТ, бусад төлбөр тооцоог тухай бүр гүйцэтгэж, холбогдох портал сайтаар тайлангийн мэдээллийг оруулан, зохих газруудад илгээв.

Тус газрын өглөг, авлагыг баталгаажуулж, хамтран ажилласан гэрээт байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн 2025 оны 04 дүгээр улирлын санхүүгийн тайлан гаргахад бэлтгэж байна.

Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 148 мэдээг <https://info.shilendans.gov.mn/> цахим хуудаст байршуулж, мэдээлсэн. Тайлант хугацаанд хугацаа болоогүй 21 мэдээ хүлээгдэж байна.

Шилэн дансны цахим системд бүх мэдээг цаг тухайд нь мэдээлж, “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т байршуулсан хэдий ч 2 төрлийн мэдээг хуулиар тогтоосон хугацааны дараа засварласанаар хугацаа хэтэрсэн төлөвт шилжсэн.

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Тайлан оруулах хэрэгсэл	Зөвлөл	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсвөө, гүйцэтгэл, эхлэлт хэмжээний шалтгаан тайлбарын хөтөдүйн засгийн ангилал	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТ-ӨЛЗИЙ НАРАНЦЭЦЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсвөө, гүйцэтгэл - Хөтөдүйн, зориулалт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТ-ӨЛЗИЙ НАРАНЦЭЦЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсвөө, өргө хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТ-ӨЛЗИЙ НАРАНЦЭЦЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
4	Байгууллагын батлагдсан орон тооца орсон өөрчлөлт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БАТ-ӨЛЗИЙ НАРАНЦЭЦЭГ	*	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтын дагуу 202 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд “Гэрэлт Хөхийн Тэнцвэрт Аудит” ХХК-ийн гүйцэтгэсэн аудитаар тус газар “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн.

Дээрх аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд 3.3 сая төгрөгийн өртөг бүхий аж ахуйн бүх ажил гүйлгээг бараа материалын орлого, зарлагаар бүртгэн, 2.8 сая төгрөгийн өртөг бүхий өглөгийн үлдэгдэлийг харилцагч байгууллага тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулсан акт үйлдсэн.

Аудитын шалгалтаар өгөгдсөн 2 зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан тухай 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хариуг хүргүүлсэн.

Тайлант оны санхүүгийн тайланд Баталгаат тооцоолол аудит ХХК-тай Санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх НТАТ/25/236/АХЭ гэрээг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулан, шалгалт хийгдэж байна.

6.1 Орлого

Үйл ажиллагааны зардлын 2025 оны 936.5 сая төгрөгийн жилийн батлагдсан төсвөөс, төсвийн хуваарийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны урсгал санхүүжилт 790.4 сая төгрөг авахаас 782.9 сая төгрөгийг авч санхүүжилтийн орлого 99.05%-н гүйцэтгэлтэй байна. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгодог 5 жилийн урамшуулалын санхүүжилт 2025 оны 4 дүгээр сард орох байсан боловч Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийн хүсэлтийг 8 дугаар сард хүлээн авч 3 албан хаагчид мөнгөн урамшууллыг олгосон.

6.2 Зарлага

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон 2025 оны эхний 11 сарын үйл ажиллагаанд 782.9 сая төгрөгний зардал гаргасан нь нийт орж ирсэн төсвийн 99.05%-г эзэлж байна.

Тайлант хугацааны туршид зардлын бүлэг дотор төсвийг хэтрэлтгүйгээр зарцуулахад анхааран ажилласан ба 2025 оны 12 дугаар сарын цалин, татвар, бусад ажил гүйлгээ хийгдэх хугацаа болоогүй тул 146.0 сая төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

6.3 Бараа материал, үнэт цаас

Тайлант хугацаанд 22.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Хангамжийн бараа материалыг батлагдсан төсвийн хүрээнд сар бүр татан авч зохих нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Баталгаажсан шаардах хуудсаар зарлага бүртгэж, зарцуулалтыг сар бүр бараа материалын тайланд тусгаж хэвшсэн.

6.4 Үндсэн хөрөнгө

2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгө 560.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Үүнээс:

- | | |
|-----------------------------|---|
| 1. Барилга, байгууламж | 486.7 сая төгрөг /2006 онд ашиглалтад орсон./ |
| 2. Авто машин | 2.0 сая төгрөг |
| 3. Машин, тоног төхөөрөмж | 25.0 сая төгрөг |
| 4. Тавилга эд хогшил | 16.1 сая төгрөг |
| 5. Биет бус хөрөнгө /газар/ | 30.7 сая төгрөгийн хөрөнгө илүүдэл дутагдалгүй, бүрэн бүтэн ашиглагдаж байна. |

2024 оны өмчийн хөдлөл өөрчлөлтийн тайланг <https://umch.sgov.mn/> төрийн өмчийн тооллогын системд 2025 оны 04 сарын 15-ны дотор илгээлээ.

6.2 ТӨБЗГ-ын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын хүрээнд

6.2.1 Барилга, байгууламж

Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг нормд заасны дагуу барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд үзлэг шалгалтыг хийж хувийн хэрэгт тэмдэглэгээ бүрэн хийгдсэн. Багануур дүүргийн автограшийн чанар аюулгүй байдал, стандарт нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах.

6.2.2 Авто машин

Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг хөтөлсөн. Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6-д заасны дагуу суудлын автомашины тоо, төрлийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар тогтоолгох.

6.2.3 Биет бус хөрөнгө /газар/

Багануур дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 2025 оны 25 дугаар сарын 17-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн Багануур дүүргийн Засаг даргын захирамжаар эзэмшил, ашиглалтад олгогдсон 2008 оноос 2025 он хүртэлх газрын захирамжийг газар эзэмших эрхийн гэрчилгээтэй тулган баталгаажуулахад 1 нэгж талбарын талбайн хэмжээ 1 м.кв-аар зөрүүтэй байна. Энэ нь газрын кадастрын нарийвчилсан хэмжээний зөрүүнээс болсон байна.

Газар эзэмших эрхийн санхүүгийн тайлангийн бүртгэлийг 2018 оны дахин үнэлгээ, 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан тус бүрд газрын нэгж талбарын хэмжээнд хөдлөл өөрчлөлт гарсан эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд нэгж талбарын хэмжээнд өөрчлөлт гараагүй гэж дүгнүүлсэн.

6.2.4 Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

НДЕГ-аас балансаас балансад шилжиж ирсэн 11 нэр төрлийн 16.34 сая төгрөгийн хөрөнгөнөөс нийт 9.91 сая төгрөгийн дүнтэй 4 компьютерын процессор, хулгана дутуу ирсэн бол 2.45 сая төгрөгийн дүнтэй 1 компьютер иж бүрдлээр БНД НДГазарт хүлээлгэж

өгөөгүй зөрчил илэрсэн. Шалгалтын хугацаанд нэг бүрийн үнэтэй 2.45 сая төгрөгийн үнэтэй 4 компьютерын дутуу ирсэн процессор хулганыг холбогдох байгууллагаас хүлээн авч зөрчлийг арилгасан. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2.4 сая төгрөгийн дүнтэй 1 ширхэг компьютерыг дутуу хүлээлгэж өгсөн зөрчлийг арилгав.



Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий Sonata 8 маркийн 2016 онд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгслийг үйлчилгээний зориулалтаар ашиглаж байгаа бөгөөд жолоочийн хариуцлагын даатгал тээврийн хэрэгслийн даатгал, шатахуун зарцуулалт, техникийн үзлэгийн талаарх мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/199 дүгээр тушаалаар батлагдсан Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журмын 4.4.5 болон авто тээврийн хэрэгслийн техникийн ашиглалтын хувийн хэргийг MNS46:2011 стандартын 7.5-т заасны дагуу техник ашиглалтын хувийн хэргийн дэвтрийг тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэг, хийсэн тухай тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, хянаж ажилласан ба 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр НДЕГ-т 03/157 албан бичиг хүргүүлсэн.



Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8.2 төгрөгийн балансын үнэ бүхий Sonata 8 маркийн 2016 онд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгслийг албан хэрэгцээнд ашиглаж байна .

Тээврийн хэрэгслийн тоо төрлийг ТӨБЗГ-ын 2025.05.01-ний өдрийн 241 дүгээр тогтоолын хавсралтын 26 дугаар мөрөнд “хот доторх ажлын суудлын автомашин жижиг” 1 ширхэг гэж тогтоосон.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн танилцуулгыг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хийж “Хангалттай” үнэлэгдлээ.

6.2.5 Өр, авлага

Тайлант оны 1 дүгээр улирлын тайлангаар ажилчидтай холбоотой өглөг 19.5 сая төгрөг, 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 1,450,337.50 төгрөг, 3 дугаар улирлын байдлаар 13.1 сая төгрөгийн өглөгтэй байсан ба 11 дүгээр сард ажилчидтай холбоотой өглөгийг бүрэн барагдуулсан.

Харуул хамгаалалтын байгууллагатай сард 0.33 сая төгрөгийн төлбөр төлөхөөр төсөвлөсөн ч төсөв 0.27 сая төгрөгөөр батлагдсанаар тайлант оны 3 дугаар улирлын байдлаар харуул хамгаалалтын зардалд нийт 0.54 сая төгрөгийн өглөг үүссэн. НДЕГ-т хүсэлт гаргаж 2025 оны 11 дүгээр сард санхүүжилтийг шийдүүлж өглөгийг бүрэн барагдуулсан.

6.2.6 Орон тоо, цалин

Багануур дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай А/12 тоот тушаалын хавсралтад зааснаар 2025 оны 3 дугаар улирлын байдлаар удирдах 4, гүйцэтгэх 14, үйлчлэх-2 /ТЗ-13, ТҮМ-4, ТҮ-3/ нийт батлагдсан 20 орон тоогоор ажиллаж байсан.

Харин Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/238 дугаар тушаал, тус газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар 2025 оны 10 дугаар сарын 15-аас удирдах 4, гүйцэтгэх 13, үйлчлэх 1 нийт 18 орон тоогоор ажиллаж байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болон маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүдэд 2025 оны 01-03 дугаар сарыг дуустал нэг цагийн 15,716 төгрөг, 04 дүгээр сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой нэг цагийн 18,860 төгрөгөөр хурлын ирцийн цаг бүртгэлийг үндэслэн мөнгөн урамшууллыг тооцож, сар бүр батлагдсан төсвөөс олгож, нийгмийн даатгалын болон татварын тайланг хуулийн хугацаанд илгээж байна.

6.2.7 Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүд төрийн өмчийн программд байгууллагад бүртгэлтэй 1,034.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шивж бүртгэлжүүлсэн ба ажлаас чөлөөлөгдсөн 3, шинээр томилогдсон 2, албан тушаалд шилжин томилогдсон 3 албан хаагчийн ажил хүлээлцэх комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, эд хариуцагчийн бүртгэлийг тухай бүр өөрчлөв.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 127 төрлийн 8390 ширхэг 7.1 сая төгрөгийн эд материалын худалдан авалт хийж, 203 нэр төрлийн 6607 ширхэг 10.6 сая төгрөгийн материалыг албан хэрэгцээнд зарцуулж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлж, сар бүр тайлагнав. Агуулахад байгаа бараа материалыг төрөлжүүлэн, цэгцэлж хураав.

№	Нэр	Хэмжээ	Нэгж	Үнэ
1	Хүнсний бараа	100	кг	1000000
2	Техникийн бараа	50	шт	2000000
3	Хүмүүний нөөц	10	төг	10000000
4	Хөрөнгийн зээл	500000000	төг	500000000
5	Хөрөнгийн зээл	1000000000	төг	1000000000
6	Хөрөнгийн зээл	1500000000	төг	1500000000
7	Хөрөнгийн зээл	2000000000	төг	2000000000
8	Хөрөнгийн зээл	2500000000	төг	2500000000
9	Хөрөнгийн зээл	3000000000	төг	3000000000
10	Хөрөнгийн зээл	3500000000	төг	3500000000
11	Хөрөнгийн зээл	4000000000	төг	4000000000
12	Хөрөнгийн зээл	4500000000	төг	4500000000
13	Хөрөнгийн зээл	5000000000	төг	5000000000
14	Хөрөнгийн зээл	5500000000	төг	5500000000
15	Хөрөнгийн зээл	6000000000	төг	6000000000
16	Хөрөнгийн зээл	6500000000	төг	6500000000
17	Хөрөнгийн зээл	7000000000	төг	7000000000
18	Хөрөнгийн зээл	7500000000	төг	7500000000
19	Хөрөнгийн зээл	8000000000	төг	8000000000
20	Хөрөнгийн зээл	8500000000	төг	8500000000
21	Хөрөнгийн зээл	9000000000	төг	9000000000
22	Хөрөнгийн зээл	9500000000	төг	9500000000
23	Хөрөнгийн зээл	10000000000	төг	10000000000
24	Хөрөнгийн зээл	10500000000	төг	10500000000
25	Хөрөнгийн зээл	11000000000	төг	11000000000
26	Хөрөнгийн зээл	11500000000	төг	11500000000
27	Хөрөнгийн зээл	12000000000	төг	12000000000
28	Хөрөнгийн зээл	12500000000	төг	12500000000
29	Хөрөнгийн зээл	13000000000	төг	13000000000
30	Хөрөнгийн зээл	13500000000	төг	13500000000
31	Хөрөнгийн зээл	14000000000	төг	14000000000
32	Хөрөнгийн зээл	14500000000	төг	14500000000
33	Хөрөнгийн зээл	15000000000	төг	15000000000
34	Хөрөнгийн зээл	15500000000	төг	15500000000
35	Хөрөнгийн зээл	16000000000	төг	16000000000
36	Хөрөнгийн зээл	16500000000	төг	16500000000
37	Хөрөнгийн зээл	17000000000	төг	17000000000
38	Хөрөнгийн зээл	17500000000	төг	17500000000
39	Хөрөнгийн зээл	18000000000	төг	18000000000
40	Хөрөнгийн зээл	18500000000	төг	18500000000
41	Хөрөнгийн зээл	19000000000	төг	19000000000
42	Хөрөнгийн зээл	19500000000	төг	19500000000
43	Хөрөнгийн зээл	20000000000	төг	20000000000
44	Хөрөнгийн зээл	20500000000	төг	20500000000
45	Хөрөнгийн зээл	21000000000	төг	21000000000
46	Хөрөнгийн зээл	21500000000	төг	21500000000
47	Хөрөнгийн зээл	22000000000	төг	22000000000
48	Хөрөнгийн зээл	22500000000	төг	22500000000
49	Хөрөнгийн зээл	23000000000	төг	23000000000
50	Хөрөнгийн зээл	23500000000	төг	23500000000
51	Хөрөнгийн зээл	24000000000	төг	24000000000
52	Хөрөнгийн зээл	24500000000	төг	24500000000
53	Хөрөнгийн зээл	25000000000	төг	25000000000
54	Хөрөнгийн зээл	25500000000	төг	25500000000
55	Хөрөнгийн зээл	26000000000	төг	26000000000
56	Хөрөнгийн зээл	26500000000	төг	26500000000
57	Хөрөнгийн зээл	27000000000	төг	27000000000
58	Хөрөнгийн зээл	27500000000	төг	27500000000
59	Хөрөнгийн зээл	28000000000	төг	28000000000
60	Хөрөнгийн зээл	28500000000	төг	28500000000
61	Хөрөнгийн зээл	29000000000	төг	29000000000
62	Хөрөнгийн зээл	29500000000	төг	29500000000
63	Хөрөнгийн зээл	30000000000	төг	30000000000
64	Хөрөнгийн зээл	30500000000	төг	30500000000
65	Хөрөнгийн зээл	31000000000	төг	31000000000
66	Хөрөнгийн зээл	31500000000	төг	31500000000
67	Хөрөнгийн зээл	32000000000	төг	32000000000
68	Хөрөнгийн зээл	32500000000	төг	32500000000
69	Хөрөнгийн зээл	33000000000	төг	33000000000
70	Хөрөнгийн зээл	33500000000	төг	33500000000
71	Хөрөнгийн зээл	34000000000	төг	34000000000
72	Хөрөнгийн зээл	34500000000	төг	34500000000
73	Хөрөнгийн зээл	35000000000	төг	35000000000
74	Хөрөнгийн зээл	35500000000	төг	35500000000
75	Хөрөнгийн зээл	36000000000	төг	36000000000
76	Хөрөнгийн зээл	36500000000	төг	36500000000
77	Хөрөнгийн зээл	37000000000	төг	37000000000
78	Хөрөнгийн зээл	37500000000	төг	37500000000
79	Хөрөнгийн зээл	38000000000	төг	38000000000
80	Хөрөнгийн зээл	38500000000	төг	38500000000
81	Хөрөнгийн зээл	39000000000	төг	39000000000
82	Хөрөнгийн зээл	39500000000	төг	39500000000
83	Хөрөнгийн зээл	40000000000	төг	40000000000
84	Хөрөнгийн зээл	40500000000	төг	40500000000
85	Хөрөнгийн зээл	41000000000	төг	41000000000
86	Хөрөнгийн зээл	41500000000	төг	41500000000
87	Хөрөнгийн зээл	42000000000	төг	42000000000
88	Хөрөнгийн зээл	42500000000	төг	42500000000
89	Хөрөнгийн зээл	43000000000	төг	43000000000
90	Хөрөнгийн зээл	43500000000	төг	43500000000
91	Хөрөнгийн зээл	44000000000	төг	44000000000
92	Хөрөнгийн зээл	44500000000	төг	44500000000
93	Хөрөнгийн зээл	45000000000	төг	45000000000
94	Хөрөнгийн зээл	45500000000	төг	45500000000
95	Хөрөнгийн зээл	46000000000	төг	46000000000
96	Хөрөнгийн зээл	46500000000	төг	46500000000
97	Хөрөнгийн зээл	47000000000	төг	47000000000
98	Хөрөнгийн зээл	47500000000	төг	47500000000
99	Хөрөнгийн зээл	48000000000	төг	48000000000
100	Хөрөнгийн зээл	48500000000	төг	48500000000



ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн тус газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2024 онд 6, 2025 онд 9 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө хэрэгжүүлж, 2025 онд зөвлөл 2 удаа хуралдаж, 1 зөвлөмжийг гаргасан.

Хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, барилга, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтэрт тэмдэглэл хийсэн байдал, тооллогын ажилд хяналт тавьж ажиллаж байна.

ДОЛОО.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ЧАНАР, ХУГАЦАА

7.1 Дээд газрын ирүүлсэн тогтоол, шийдвэрийг бүртгэж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах

2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар дээд газраас ирүүлсэн 45 эрх зүйн актыг хэрэгжүүлэн ажиллав.

Ирүүлсэн шийдвэрийг төрлөөр нь авч үзвэл:

№	Эрх зүйн актын нэр	Тоо
1	Монгол Улсын хууль	4
2	Засгийн газрын тогтоол	6
3	ХНТ-ийн Гурван талт үндэсний хорооны тогтоол	1
4	НДҮЗ-ийн тогтоол	3
5	ЭМ-ийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	1
6	НДЕГ-ын даргын тушаал	21
7	НДЕГ-ын даргын албан даалгавар	1
8	Ерөнхий сайдын захирамж	1
9	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	7
	Нийт	45


7.2 Үйлчилгээ, өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, хяналт

Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авахаар иргэд, даатгуулагчдын ирүүлсэн хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгэж, бүртгэл хяналтын карт хөтлөн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, явц, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 1733 хүсэлт бүртгэгдсэнээс 92,4%-ийг шийдвэрлэж ажиллав. Тэтгэвэр тогтоолгох цалингийн 2025 оны итгэлцүүр өөрчлөн батлагдсантай холбоотой Sicos программд өөрчлөлт хийх ажил хүлээгдсэнээс шалтгаалан 2025 оны 01 дүгээр сарын шинэ тэтгэврийн тогтоолт, олгох ажлууд удааширч 53 өргөдөл, 2024 оны жилийн эцсийн тайлан гаргахтай холбоотой сайн дурын даатгалын 4 өргөдөл хугацаа хэтэрч шийдэгдсэн бол тэтгэмжийн байцаагч албан ажлын шаардлагаар 2025.02, 03 дугаар сард үйл ажиллагааны нябо-г хавсарч ажилласан хугацаанд Төрийн өмчийн программд үндсэн хөрөнгийн мэдээлэл шивж, тайлан гаргах, НДЕГ-аас шалгалт ирсэн үеийн ажлын ачаалал огцом өссөнөөс тэтгэмжийн 49 өргөдөл тус тус хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

Нийгмийн даатгалын цогц системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлаас шалтгаалан зарим даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох ажлууд удааширснаас үүдэн 11-11 төвд 7 гомдол бүртгэгдсэнийг тухай бүр судлан шийдвэрлэж, иргэдэд хариу хүргүүлж ажилласан.

Тус газраас иргэд, даатгуулагчдад хүргэсэн үйлчилгээ, тус газарт хандсан гомдлыг сүүлийн 3 жилийн мөн үеэр харьцуулан харуулбал:



2025 оны 3 дугаар улирлын өргөдөл, гомдлын тайланг гаргаж, 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдөр НДЕГ-ын ДАМГ-т хүргүүлсэн.

7.3 Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт (MNS5140:2021-1, 2, 3), Засгийн газрын 2025 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, Монгол хэлний тухай хуулийн 7.2. дах хэсэгт заасны дагуу үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна, 11.1.2.монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх гэсэн заалтын дагуу архив, албан хэрэг хөтлөлтөө хөтөлж байна.



2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс архив, албан хэрэг хөтлөлтөө хос бичгээр хөтлөнө гэсний дагуу монгол бичгийн 4 төрлийн хэвлэмэл хуудасны загварыг шинэчлэн Нийслэлийн архивын газарт захиалга өгч, хэвлүүлсэн.

Албан хэрэг хөтлөлтийн edoc дэд системээр нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудтай, able программаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн Нийгмийн даатгалын газартай албан бичиг солилцон ажиллаж байна.

Цаасаар ирүүлсэн 184 албан бичгийг edoc.ulaanbaatar.mn системд бүртгэж, гадагш илгээсэн 222 албан бичгийг системээр боловсруулав.

Тус газраас гадагш илгээж буй албан бичгийг edoc системийн баримт боловсруулалт цэсээр боловсруулах ажлыг хэвшүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулан илгээж, үндэсний бичгээр хөрвүүлж, байгууллагад үлдэх хувийг хэвлэмэл хуудсанд буулган архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдөн ажиллалаа.

7.4 Авлига гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Тус газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд ёс зүй, харилцаа хандлага, сахилга хариуцлагатай холбоотой зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.

Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 3 зорилт 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 90%-иар ханган ажиллав.

Өмнөх жил буюу 2024 оны ХАСХОМ-ийг 7 албан хаагч 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан мэдүүлж, тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэв.

Тайлант оны байдлаар шинээр ажилд томилогдсон 2, шилжиж явсан 1, шилжиж ирсэн 1, чөлөөлөгдсөн 2, нийт 7 албан хаагчийн өөрчлөлт хөдөлгөөн гарсан. Шинээр томилогдсон 2 албан хаагч ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэхгүй, шилжүүлэн томилогдсон албан хаагч нь ТЗ-7 зэрэглэлээс ТЗ-8 зэрэглэлд буурч шилжсэн тул ХАСУМ, ХАСХОМ мэдүүлээгүй болно. Нэг албан хаагч их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүллээ.

НДЕГ-ын даргын 2025.09.10-ны өдрийн А/238 дугаар “Дүүргийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтаар Багануур дүүргийн нийгмийн даатгалын газрыг 3 хэлтэс, 18 албан хаагчтай байхаар баталсан.

Дээрх тушаалтай холбоотойгоор НДЕГ-ын даргын 2025.09.16-ны өдрийн 03/2241 “Тушаал, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу нийт 6 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулж, төрийн байгууллагын үйлчилгээний ажилтан албан тушаал дээр нэг албан хаагчийг цомхотгосон. Хүний нөөцийн хөдөлгөөнтэй холбоотойгоор 3 албан хаагчийн ХАСУМ-ыг журамд заасны дагуу АТГ-т илгээж хариуг авсанаар албан тушаалд томилогдсон. Тайлант онд ЭБАТ 2 удаа солигдож тухай бүр ажлыг хүлээлцүүлэв.

АТГ-аас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч түгээлээ. Мөн тус газраас нийтэлсэн 13 удаагийн постыг олон нийтийн цахим сүлжээнд нийтлэв. Хүснэгтээр харуулбал:

№	Огноо	Эх сурвалж	Линк
1	2025.05.28	АТГ	https://www.facebook.com/bnd.ndh.page/posts/pfbid02Bnk5hBcrYAeayVVdsMwuirTwwZnrA1pt6yjAjbsKX3QYmwiYH4rPz2NxmF252iXFI
2	2025.06.05	АТГ	https://www.facebook.com/share/p/1P3Ym7R4dQ/
3	2025.06.20	АТГ	https://www.facebook.com/share/p/1AEgd7ANAm/
4	2025.07.02	АТГ	https://www.facebook.com/share/p/16Vbhtviv3/
5	2025.07.03	АТГ	https://www.facebook.com/share/p/18R6gKKJYd/
6	2025.07.24	АТГ	https://www.facebook.com/share/p/1AEgd7ANAm/
7	2025.08.13	АТГ	https://www.facebook.com/share/p/1E9J2XrbR5/
8	2025.09.05	АТГ	https://www.facebook.com/share/p/1BcbhTThUj/
9	2025.09.29	АТГ	https://www.facebook.com/share/p/1Gujayq1Ch/
10	2025.09.30	АТГ	https://www.facebook.com/share/p/1Gujayq1Ch/
11	2025.10.24	АТГ	https://www.facebook.com/share/p/1ABWgkevUo/
12	2025.10.30	АТГ	https://www.facebook.com/share/p/1MwQ3UQdYf/
13	2025.12.01	АТГ	https://www.facebook.com/share/p/14S1ZF1mWWn/

Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнээс дээш их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор мэдээлэх гэсний дагуу нийт албан

хаагчдад, түүний дундаас ХАСХОМ гаргагч нарт онцлон сануулж, хууль хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

Мөн газраас зохион байгуулсан сургалтад магадлагч эмч, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд нийт 10 хүн оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв.

7.5 Хүний нөөцийн чиглэлээр

Тус газар нь 2025 оны 11 сарын байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан зохион байгуулалтын 3 хэлтэс, удирдах 4, гүйцэтгэх 14 нийт 18 албан хаагчтайгаар ажиллаж байна.



Хүний нөөцийн үзүүлэлтийг боловсролын зэрэг, гендер, насны ангилал, салбарт ажилласан хугацаагаар ангилан харуулбал дараах байдалтай байна.



Боловсролын зэрэг: Магистр 27%
Бакалавр 67%
Бүрэн дунд 6%



Гендер
Эрэгтэй 16%
Эмэгтэй 84%



Салбарт ажилласан жил:
5 хүртэл жил 38%
5-9 жил 24%
10-14 жил 27%
15-аас дээш жил 11%



Насны ангилал:
25-34 нас 33%
35-44 нас 33%
45-54 нас 34%

Тайлант хугацаанд орон тооны хэтрэлтгүй ажиллаж, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний 10 удаагийн мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний мэдээ

- хүүхдээ асарч байгаа - 1 албан хаагч
- шинээр ажилд томилогдсон - 2 албан хаагч
- шилжиж явсан - 1 албан хаагч
- шилжиж ирсэн - 1 албан хаагч
- өөрийн саналаар чөлөөлөгдсөн - 3 албан хаагч
- цомхотголд орсон - 1 албан хаагч
- Байгууллага дотор шилжүүлсэн - 6 албан хаагч

(2025 оны Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, албан тушаалын өөрчлөлт)

Нийт 14 албан хаагчийн хөдөлгөөнийг холбогдох хүний нөөцийн программд бүртгэж хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн нийт албан хаагчдын 70%-ийг эзэлж байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас 8 байцаагч буюу 67% нь улсын байцаагчийн эрхтэй байна.

Тайлант хугацаанд хүний нөөцтэй холбоотой 23, бусад 10 нийт 33 төрлийн судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлээ.



7.6 Стресс менежмент хөтөлбөрийн хүрээнд

“Стресс менежмент” сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр нийт албан хаагч нарын дунд зохион байгуулж стрессийн талаарх анхан шатны мэдлэгийг олгосон. Хүний нөөцийн ажилтан ажлын байранд нийтлэг стресс үүсгэгч байгаа эсэхийг судлан тогтоож нийт албан хаагчдад танилцуулан стрессийг хэрхэн даван туулах талаар 2 удаагийн сургалт зохион байгуулав.


Тус газрын 16 албан хаагчийг эрүүл мэндийн анхан шатны үзлэг, эрдсийн шинжилгээнд хамруулан албан хаагч нэг бүрийн эрүүл мэндийн байдалтай танилцлаа. Нийт албан хаагчдын 75%-нь хоол боловсруулах үйл ажиллагаа доголдсон байсан нь стрессийн түвшин өндөр байгааг харуулж байгаа нэг үзүүлэлт болж байна.

Нийт албан хаагчдын 12 албан хаагч буюу 75% нь хоол боловсруулах эрхтний доголдол илэрсэн.

Нийт албан хаагчдын 4 албан хаагч буюу 22% нь хурдан санах, мартаж мэдрэлийн тогтолцооны эрхтний доголдол илэрсэн.

Нийт албан хаагчдын 11 албан хаагч буюу 61% нь D витамин, цайр, ханаагүй тосны хүчлийн дутагдал илэрсэн.

Албан хаагчдын тоо



■ Эрүүл мэндийн үзүүлэлт сайн ■ Эрүүл мэндийн үзүүлэлт дунд ■ Эрүүл мэндийн үзүүлэлт муу

Дээрх сэтгэцийн эрүүл мэндийн болон биеийн ерөнхий эрүүл мэндийн судалгаануудын үр дүнд албан хаагч нарын эрүүл мэндийг хамгаалах олон улсын шинэ жишгийг нэвтрүүлэх шаардлага байгааг илтгэж байна. Мөн стресс тайлах энгийн арга, судалгаа, өөрийгөө танин мэдэх чиглэлээр шинжилгээний баг зөвлөгөө өгсөн.

Газрын даргын А тушаал 24, Б тушаал 45 нийт 69 тушаалын хуулийн ишлэлийг хянаж, эрхзүйн чиглэлээр ирүүлсэн 2 судалгааг гаргасан.

НАЙМ. ДҮҮРЭГ БОЛОН БАЙГУУЛЛАГА ОРЧНОО ТОХИЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 62 дугаар зарлигаар “Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласан.

Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-т Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 08/525 дугаар албан бичгээр ирүүлсэн дүүргийн арга хэмжээнд зориулан Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу мөнгөн хандивыг 1 ажилтны 10000 төгрөгөөр тооцож нийт 20 ажилтны 0.2 сая төгрөгийг Төрийн сан банкны 100200255204 тоот дансанд төвлөрүүлэн байгууллага, дүүрэг орчноо тохижуулах ажилд мөнгөн хандив өргөж хувь, нэмэр оруулав.

Мөн тус газрын албан хаагчид тус 2025 оны 10 дугаар сард “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн үйл ажиллагаанд Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс ирүүлсэн албан бичгийн оролцож Багануур дүүргийн 1 дүгээр хороонд байрлалтай Нарангийн ухаа 3га талбайд шинээр мод тарих ажлыг гүйцэтгэв.

Тус газар нь өөрийн эзэмшлийн талбайд 2012 оноос эхлэн жил бүр нэмж, нөхөн тарилт хийсэн монос, улиас, шинэс, модлог хуайс, шар хуайс, гүйлс, буйлс, голт бор, гацуур, далийн ягаан, нохойн хошуу, тавилгана зэрэг 12 төрлийн 400 орчим, ойр орчмын нийтийн эзэмшлийн талбайд агч, хайлаасын 2 төрлийн 30 ширхэг модыг тарьж ургуулан, усалгаа, арчилгааг жил бүр тогтмол хийж байна.

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу бүх нийтээр цас, хог цэвэрлэх 13 удаагийн үйл ажиллагаанд оролцож, өөрийн болон нийтийн эзэмшлийн зам, талбайн цас, ногоон бүс, хотын төвийн хуваарьт талбай, хэлтсийн хашааны дотор, гадна эргэн тойрны шар өвс, хогийг цэвэрлэх, цонх, хашаа, хайс, албан тасалгааны орчныг угаах ажлыг гүйцэтгэсэн.

ЕС. АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 10-нд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлээ.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд ажил, ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хэлтсийн даргын 2019 оны А/31 дүгээр тушаалаар 16 хүртэлх насны хүүхдийн төрсөн өдрөөр ажилтанд цалинтай чөлөө олгох шийдвэрийн дагуу 7 албан хаагчид 8 өдрийн цалинтай чөлөө олгов.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд бага насны олон хүүхэдтэй 1 албан хаагчийг цахимаар ажиллуулав.

Хүний нөөцийн нэгдсэн системүүдэд албан хаагчдын мэдээллийг бүртгэн, шаардлагатай тохиолдолд мэдээллийг шинэчлэн, өөрчлөлт оруулж ажиллав. Тус газрын нийт албан хаагчдын мэдээлэлд төрийн албан хаагчийн шинэчлэгдсэн цалин, даатгуулагчийн төрлийн 5 оронтой код, ажил мэргэжлийн ангиллын кодыг өөрчилж, зарим албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, зэрэг дэвийн, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тухай бүр шинэчлэн бүртгэлээ.

Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг 6% нэмэгдүүлсэн.

Ар гэрт нь гачигдал гарсан 2 албан хаагчид хэлтсийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 600,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.

ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан газрын албан хаагчдын 0-16 насны 29 хүүхдэд нийгмийн даатгалын байгууллагын ажлын онцлогийг таниулан сурталчлах “Хүүхэд бүр уншигч” сэдэвт өдөрлөг зохион байгуулсан.

Газрын даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг албан хаагчдын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авч, үр дүнд үндэслэн шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөв.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай



**ШИЛ
АЖИЛЛАГАА**
shilen.gov.mn


Тайлант хугацаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2–8.6-д заасан 37 төрлийн мэдээллийг цахим хуудсанд байршуулж, Baganuur.ndaatgal.mn сайтад нийтэлсэн мэдээллийг shilen.gov.mn системтэй холбон ажиллав. Тус онд мэдээллийн ил тод байдал, дотоод хяналт, хүний нөөцийн бодлого, үйлчилгээний чанарын чиглэлээр хууль, журамд заасан хугацаанд тайлан мэдээ, үр дүнг бүрдүүлэн хүргүүлж ажиллав. 1 дүгээр улиралд 74%, 2 дугаар улирлын үнэлгээгээр ил тод байдлын хэрэгжилт сайжирч, 91.43%-д хүрсэн бөгөөд 3 дугаар улиралд мэдээлэл буцаагдсанаас үнэлгээ хийгдээгүй, IV улиралд мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж ажиллана.

АРАВ.ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсээс уриалж буй “365 анхаарч хайрлая” аянд байгууллага нэгдэн оролцлоо. Аяны мэдээллийг тус хэлтсийн албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан нийтэлж, олон нийтэд хүргэв.

Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсээс уриалсан “Хүн бүр хүүхэд хамгаалагч” аянд тус байгууллага нэгдэн оролцлоо. Аяны хүрээнд хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор рийлс хэлбэрийн богино хэмжээний мэдээллийн бичлэгийг бэлтгэсэн.

Бэлтгэсэн рийл бичлэгийг тус газрын албан ёсны фэйсбүүк хуудсанд болон Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн фэйсбүүк хуудсанд нийтэлж, олон нийтэд хүргэсэн. Мөн Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар болон Цагдаагийн хэлтсийн албан хаагчдыг уг мэдээллийг өөрийн цахим хуудсаар түгээж, аяны зорилгыг дэмжин, хүүхэд хамгааллын зөв ойлголтыг хариуцлагатайгаар түгээхийг уриалан ажиллав.



Тус газрын гадна байрлах нийт 3 ширхэг хяналтын камераас 1 нь эвдэрсэн байсан тул шинэ камераар сольж суурилуулан ажиллагааг бүрэн хэвийн байдалд орууллаа. Ингэснээр байгууллагын гадна орчны хяналт, аюулгүй байдлыг хангах нөхцөл сайжирч, тасралтгүй хяналтын үйл ажиллагаа бүрдсэн.

Мөн байгууллагын архивын өрөөнд нэмэлт хяналтын камер суурилуулж, баримт хадгалалтын орчны хамгаалалт, хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэн ажиллав.

Дүрс бичлэгийн системийн хэвийн байдлыг сар бүр тогтмол шалгаж, хянах ажлыг хэрэгжүүлэн, хяналтын төхөөрөмжүүдийн тасралтгүй ажиллагааг баталгаажуулж ажиллаж байна.



АРВАН НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ИРГЭД, ДААТГУУЛАГЧДАД СУРТАЛЧИЛСАН БАЙДАЛ, ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, ҮР ДҮН

Тайлант хугацаанд хэрэгжүүлэх сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, мөн Захиргаа, хяналтын хэлтсийн төлөвлөгөөнд сургалт сурталчилгааны чиглэлээр хийх ажлуудыг тусгаж газрын даргаар батлуулан, мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллав.

11.1 Цахим сурталчилгаа



Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь олон нийтийг Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, сурталчлах зорилгоор тайлант хугацаанд албан ёсны Facebook хуудсаар нийт 677 нийтлэл байршуулсан. Эдгээр нийтлэл нийт 89,722 хандалт, 541 хариу үйлдэл, 87 сэтгэгдэл, 677 хуваалцал авсан байна. Мөн тус газрын зүгээс бэлтгэсэн 27 мэдээ, постер, 2 ширхэг Рийлс/видео контент, “Багануурын мэдээ” веб сайтаар дамжуулсан 7 нийтлэл олон нийтэд хүргэгдсэн ба фэйсбүүк хуудас 4162 дагагчтай болж 2,86%-р өссөн байна.

Үүнээс гадна Нийгмийн даатгалын ерөнхий газрын Facebook хуудас болон Instagram хаягийн хандалтыг нэмэгдүүлэх зорилгоор тус газрын нийт албан хаагчид тухайн хуудсуудыг дагаж, идэвхтэй ашиглаж байна.



11.2 Ажил олгогч, даатгуулагчид чиглэсэн сургалт, сурталчилгаа

Нийгмийн даатгалын тухай шинэчилсэн хууль тогтоомж, шинэчлэгдсэн программ хангамж болон цахим үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөгөө хүргэх зорилгоор ЗХХ-ийн дарга Г.Батболд “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга”, “Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлууд” сэдвийн хүрээнд нийт 16 удаагийн танхимын сургалтыг, ахлах нягтлан бодогч Ц.Солонго арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу 5 удаагийн сургалтад мэдээлэл түгээв. Тайлант хугацаанд нийт 13 удаагийн сургалт, малчдын өдөрлөг 1, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, ажил олгогчид зориулсан сургалт, зөвлөгөөнийг цувралаар зохион байгууллаа.



Эдгээр сургалтад ажил олгогч байгууллагуудын удирдах ажилтан, нягтлан бодогч зэрэг 661 даатгуулагч, иргэн оролцож, нийт 175 ажил олгогчийг хамруулсан байна.



11.3 Ажилтан, албан хаагчдад зориулсан сургалт



Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх хүрээнд сургалтын хэрэгцээг тодорхойлж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулав. Үүний дагуу албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх 99 удаагийн сургалтад давхардсан тоогоор 413 албан хаагчийг танхим болон цахимаар үр дүнтэйгээр оролцуулав.



1. Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан Г.Гантуяа Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулсан Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамрагдаж, батламж авсан.
2. Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Г.Батболд Жендэрийн үндэсний хорооны Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтад амжилттай хамрагдаж Ж-1 гэрчилгээ олгогдсон.
3. Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга Р.Өнөржаргал Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдан төгсөж, сертификат авсан.
4. Б.Балжинням магадлагч эмч, А.Ундармаа хүний нөөц, хуулийн мэргэжилтэн нар ХАБЭА-н тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг, сургалтад хамрагдан сертификат авсан.
5. Архивчдын хөгжил сургалт, арга зүйн төвөөс зохион байгуулсан "Архив, албан хэрэг хөтлөлт" сэдэвт сургалтад архивын ажилтан Т.Ганчимэг 2025 оны 10 дугаар сарын 13-24 хүртэл 14 өдрийн хугацаанд цахимаар оролцож, сертификат гардан авлаа.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН


А.УНДАРМАА



7021-0021



baganuur.ndaatgal.mn



Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар



БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025
оноос
хүлээн
засах

2025 оны
гүйцэтгэлийн
тайлан



БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 10

Багануур дүүрэг

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 12 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Тайланд онд дээд газраас ирүүлсэн 45 эрх зүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн тогтоол шийдвэрийн биелэлт урьдчилсан байдлаар 93.3%-ийн үнэлгээтэй байна.	
1.2	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл	Тухайн аймаг, дүүргийн ҮА-ны зардлын төсөв	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн	Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 786.0 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	2025.12.01-ний өдрийн байдлаар батлагдсан төсвийн хуваариар 790.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 782.9 сая төгрөгний зардал гаргасан нь нийт төсвийн 99.05%-г эзэлж байна.	

	ажиллагааны зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах;		дагуу төсвийг зарцуулсан байна.			Тайлант хугацааны туршид зардлын бүлэг дотор төсвийг хэтрэлтгүйгээр зарцуулахад анхааран ажиллсан ба 2025 оны 12 сарын цалин, татвар, бусад ажил гүйлгээ хийгдэх хугацаа болоогүй тул 146.0 сая төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.	
1.3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах;	8 сая	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 арга хэмжээ зохион байгуулсан.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 7 дугаар тогтоол, тус зөвлөлийн 2025 оны 06 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/74 дүгээр тушаалын хавсралтад зааснаар Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахаар тендер шалгаруулж, 2025.07.02-ны өдөр “Өлзийт Индэр” НҮТББ гэрээ байгуулсан. 2025.07.04-ний өдөр Багануур дүүргийн нийт 68 инженер, ХАБЭА-н ажилтнуудыг “Багануур батареј 110/35кВ-н дэд станц”-тай танилцуулж, эрсдэлийг хэрхэн тооцоолох, дүгнэлт хэрхэн гаргах арга зүйн зөвлөмжийг хүргэсэн. Багануур дүүргийн нийт 112 байгууллагын 152 гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтэн нарт 2025.09.29-ний өдөр осолд дөхсөн тохиолдолд авах арга хэмжээ, түүний бүртгэл, мөн үйлдвэрийн осолд өртсөн бол	

						хууль зүйн туслалцаа хэрхэн авах, нийгмийн даатгалд хэрхэн даатгуулах, яагаад бүх албан хаагчаа “Үйлдвэрийн осол мэргэшлээс шалтгаалах өвчний даатгал”-д даатгуулах ёстойг тайлбарлаж өглөө. Энэхүү сургалтын үр дүнг үнэлэхийн тулд 2024,2025,2026 онуудад гарсан Үйлдвэрийн ослын мэдээ тайланг үндэслэн гаргахыг Магадлагч эмч, мэргэжилтэн Б.Балжиннямд даалгалаа. Сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/250 дугаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-н дагуу тайлагнаж ажиллаа.	
1.4	Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;	-	2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна.		Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна.	Тайлант онд хагас, бүтэн жилээр 2 удаа судалгаа авч үр дүнг НДЕГ-т 2025.10.29-нд хүргүүлсэн. Цахим үйлчилгээний талаарх мэдээллийн хэрэгцээ хамгийн өндөр байсан бөгөөд иргэд мэдээллээ голчлон нийгмийн сүлжээгээр болон байцаагчаас авдаг. Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр болон шимтгэлийн тайлан өгөх үйлчилгээнүүдийг чухалчилдаг.	

						Сүүлийн хагас жилд оролцогчдын 90.9% нь мэдээлэл, зөвлөгөөг хангалттай авсан гэж үнэлсэн. Сэтгэл ханамжийг бууруулж буй нийтлэг хүндрэлүүд нь: Бичиг баримт бүрдүүлэх төвөгтэй байдал Мэдээллийн бүрэн бус байдал Танхимын зохион байгуулалт, мэдээллийн хүртээмж Эдгээр нь мэдээлэл түгээх сувгийг сайжруулах, цахим үйлчилгээний ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.	
Гүйцэтгэлийн дундаж хувь							
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Зорилт 2: “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ .	Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 46,400.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.	НДЕГ-ын төвлөрсөн орлогын 42,902.6 сая төгрөг харилцах дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.	Төвлөрсөн орлогын харилцах дансанд ажил олгогч, даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, алданги, торгуулийн орлогыг төрийн сангийн цахим системээр дамжуулж Төрийн сан дахь төвлөрсөн орлогын харилцах дансны үлдэгдлийг тухай бүр, арилжааны банк дахь төвлөрсөн орлогын үлдэгдлийг өдөр бүр тус тус төвлөрүүлэн журмын хэрэгжилтийг ханган ажиллаж тайлант хугацаанд 39.083,19 сая	

	заалтыг хэрэгжүүлж ажиллах.					төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.	
2.2	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагч дад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна. в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулж тэтгэврийг сар бүрийн 1-ний өдөр, тэтгэмж, төлбөр, зардлыг тухай бүр арилжааны банкаар дамжуулан олгож байна. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд нийт Төлөвлөгөө 64,463.0 сая.төг Гүйцэтгэл 62,730.8 сая.төг зарцуулж ажилласан байна. Үүнд: Тэтгэврийн даатгалын сан Төлөвлөгөө 56,583.0 сая.төг Гүйцэтгэл 56,216.6 сая.төг Хэмнэлт 366.4 сая.төг Тэтгэмжийн даатгалын сан Төлөвлөгөө 2,738.0 сая.төг Гүйцэтгэл 2,665,8 сая.төг Хэмнэлт 72.2 сая.төг ҮОМШӨ-ний даатгалын сан Төлөвлөгөө 3,701.3 сая.төг Гүйцэтгэл 2,404,0 сая.төг Хэмнэлт 1,297.3 сая.төг Ажилгүйдлийн даатгалын сан Төлөвлөгөө 1,440.7 сая.төг Гүйцэтгэл 1,444.4 сая.төг Хэтрэлт 3.7 сая.төг	
2.3	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.		Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн	Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан.	а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин,	2025.12.01-ний өдрийн байдлаар батлагдсан төсвийн хуваариар 790.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 782.9 сая төгрөгийг зардлыг хууль, тогтоомжийн дагуу зарцуулсан.	

			зарцуулахгүй, ажиллагсадтай ай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.		шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	Тус газрын 2025 оны 1 дүгээр улирлын тайлангаар ажилчидтай холбоотой өглөг 19.5 сая төгрөг, 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 1.4 сая төгрөгийн өглөгтэй байсан ба 3 дугаар улиралд ажилчидтай холбоотой өглөгийг бүрэн барагдуулсан.	
2.4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	Sicos санхүүгийн шинэ программаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргасан. Мөн 2025 оны эхний хагас жил болон 3 дугаар улирлын сангийн тайланг Сикос системээр гарган ажилласан. Нийгмийн даатгалын сангийн 2025 оноос сикос системээр 1- 11 сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн. Санхүүгийн өдөр тутмын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем https://finance.gov.mn , алба хаагчдын цалин хөлсийг төрийн албаны цалингийн нэгдсэн систем https://payroll.gov.mn/ - ээр тооцож НДШ, ХХОАТ, бусад төлбөр хураамж, татвар шимтгэл, суутгалыг тухай бүр шилжүүлж тайланг холбогдох портал сайтаар гаргаж, хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. Сар бүрийн мэдээг дараа сарын 02-ны өдрийн дотор НДЕГ-т	

						хүргүүлэн, улирлын тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөв, үндэслэлтэй гаргасан. 2025 оны 1,2,3 улирлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэн ажилласан. . 2025 оны 4 дүгээр улирлын тайлан гарах хугацаа болоогүй ба тус тайланг хугацаанд нь гаргаж ажиллана.	
2.5	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах.		Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна.	-Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ/ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах,	2024 оны үндсэн хөрөнгийн тооллого, өмчийн өөрчлөлтийн тайланг https://umch.sgov.mn/ төрийн өмчийн тооллогын системд 2025.04.15-ны дотор илгээсэн. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант оны 01 дүгээр сард 2025 онд хэрэгжүүлэх 9 үзүүлэлт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулан, ажилласан. ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 65 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн тус газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2024 онд 6, 2025 онд 9 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө хэрэгжүүлж, 2025 онд зөвлөл 2 удаа хуралдаж, 1 зөвлөмжийг гаргасан. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, барилга, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтэрт тэмдэглэл хийсэн байдал, тооллогын ажилд хяналт тавьж ажиллаж байна.Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад	

					хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх; -Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх; -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах; -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах; -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна.	шаардлагатай 49 төрлийн 3297 ширхэг 2.7 сая төгрөгийн эд материалын худалдан авалт хийж, 141 нэр төрлийн 2897 ширхэг 4.0 сая төгрөгийн материалыг албан хаагчдын албаны хэрэгцээнд өгч, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны материалыг бүрдүүлж, тайланг сар бүр хугацаанд нь гарган ажилласан. Тайлант оны 04 дүгээр сард ТӨБЗГ-аас тус газрын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар НДЕГ-аас балансаас балансад шилжиж ирсэн 11 нэр төрлийн 16.34 сая төгрөгийн хөрөнгөнөөс нийт 9.91 сая төгрөгийн дүнтэй 4 компьютерын процессор, хулгана дутуу ирсэн бол 2.45 сая төгрөгийн дүнтэй 1 компьютер иж бүрдлээр БНД НДГазарт хүлээлгэж өгөөгүй зөрчил илэрсэн. Шалгалтын хугацаанд нэг бүрийн үнэтэй 2.45 сая төгрөгийн үнэтэй 4 компьютерын дутуу ирсэн процессор хулганыг холбогдох байгууллагаас хүлээн авч зөрчлийг арилгасан. Тээврийн хэрэгслийн тоо төрлийг ТӨБЗГ-ын 2025.05.01-
--	--	--	--	--	---	--

					ний өдрийн 241 дүгээр тогтоолын хавсралтын 26 дугаар мөрөнд “хот доторх ажлын суудлын автомашин жижиг” 1 ширхэг гэж тогтоосон. Газар эзэмших эрхийн санхүүгийн тайлангийн бүртгэлийг 2018 оны дахин үнэлгээ, 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан тус бүрд газрын нэгж талбарын хэмжээнд хөдлөл өөрчлөлт гарсан эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд нэгж талбарын хэмжээнд өөрчлөлт гараагүй гэж дүгнүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын биелэлтийн танилцуулгыг 2025.11.10-ны өдөр хийж “Хангалттай” үнэлэгдлээ. 2025 оны актлах, дахин үнэлэх хөрөнгийн жагсаалтыг гарган, өмч хамгаалах байнгын зөвлөл хуралдаж 2025.11.05-ны өдөр 03/194 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2025.11.30-ны өдрийн байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгө 560.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна. Үүнээс: 1. Барилга, байгууламж 486.7 сая төгрөг /2006 онд ашиглалтад орсон./ 2. Авто машин 2.0 сая төг	
--	--	--	--	--	--	--

						3.Машин, тоног төхөөрөмж 25.0 сая төгрөг 4.Тавилга эд хогшил 16.1 сая 5. Биет бус хөрөнгө /газар/ 30.7 сая төгрөгийн хөрөнгө илүүдэл дутагдалгүй, бүрэн бүтэн ашиглагдаж байна.	
2.6	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.		Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.	а)Нийгмийн даатгалын 2024 оны санхүүгийн тайланд Гэрэлт Хөхийн тэнцвэрт аудит ХХК аудит хийж, “Өөрчлөлтгүй” дүгнэлт ирүүлсэн. б) 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд 3.3 сая төгрөгийн өртөг бүхий аж ахуйн бүх ажил гүйлгээг бараа материалын орлого, зарлагаар бүртгэн тайлагнасан. 2.8 сая төгрөгийн өртөг бүхий өглөгийн үлдэгдэлийг харилцагч байгууллага тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулсан акт үйлдсэн. Аудитын шалгалтаар өгөгдсөн 2 зөвлөмж биелэлтийг хангаж, 2024.03.27-ны өдөр аудитын байгууллагад хүргүүлсэн. Аудитаар өгсөн зөвлөмжийн шилэн дансны сангийн мэдээллийг тухай бүр, сар бүр, долоо хоног бүр тогтмол оруулж ажиллаж байна. Тайлант оны санхүүгийн тайланд Баталгаат тооцоолол аудит ХХК-тай Санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх НТАТ/25/236/АХЭ гэрээг 2025.10.13-ны өдөр	

						байгуулан, шалгалт хийгдэж байна.	
2.7	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх.		Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Арилжааны банкуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, гэрээний 2.10 дахь заалтын хүрээнд 2025 оны 1-р улиралд арилжааны 4 банкны ажилтан, албан хаагч нарт тус газрын ЗХУХэлтсийн дарга, СБХОХэлтсийн дарга, ахлах нягтлан нар нийгмийн даатгалын талаарх холбогдох мэдээллийг өгч анхаарах асуудлын талаар ойлголт, мэдээлэл солилцож, сургалтыг банкууд дээр очин зохион байгуулан хамтран ажиллалаа. Өдөр бүрийн сангийн төвлөрсөн орлогыг НДЕГ-т төвлөрүүлэхэд банкуудад хяналт тавин анхаарч ажиллаж байна. 2024 онд арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэн 2025.01.15-ны өдөр НДЕГ-ын СБГазарт хүргүүлсэн.	
2.8	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн	Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байхад анхааран ажиллаж байна. 2025.11.30-ны өдрийн байдлаар Төрийн банкны ажилтны алдаанаас үүдсэн 2 гүйлгээ, нийгмийн даатгалын ажилтны	

					сан байна.	бүрдүүлсэн алдаатай холбоотой 2 гүйлгээг тухай бүр залруулсан. Арилжааны банкаар ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг буруу оруулсан тохиолдолд даатгуулагч болон банктай утсаар холбогдож, мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэхэд хяналт тавин ажиллаж харилцагч тодорхойгүй гүйлгээг тухай бүр орлого орсон банк, гүйлгээний утга дээрх утасны дугаар, холбогдох бусад арга хэмжээг авч тодруулан гүйлгээ тус бүрийн үндсэн харилцагчийг зөв таниулахад анхааран ажилласан.	
2.9	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.		ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажиллах хүрээнд сангийн нягтлан бодох бүртгэлийн системийн шинэчлэлтэй холбоотойгоор Sicos програмд банкнаас файл уншуулах татах, харилцагч таниулах, урьдчилж орсон орлого үүсгэх, тэтгэвэр, тэтгэмжийн хаалт хийх зэрэг ажлыг тухай бүр тогтмол хийж гүйцэтгэж, сангийн сарын мэдээг тус системээр гаргаж хэвшээд байна.	
2.10	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж,	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн	2025.11.30-ны өдрийн байдлаар Нийгмийн даатгалын байгууллагын хувьд 2025 оны I улирлын тайлангаар ажилчидтай холбоотой өглөг 19.5 сая төгрөг, 2025 оны II	

	шинэчлэн баталгаажуулах		тооцоо нийлсэн актаар баталгаажуу лна.		холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	дугаар улирлын байдлаар 1.4 сая, III улирлын байдлаар 13.9 сая төгрөгийн өглөгтэй байсан ба 11 дүгээр сард ажилчидтай холбоотой өглөгийг бүрэн барагдуулсан. Хамтран ажиллагч гэрээт байгууллагуудын холбогдох анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг шилжүүлж байна. Гэрээний хугацаа дуусгавар болсон 8 байгууллагын гэрээг сунгаж, шинээр 4 байгууллага болон хувь хүнтэй гэрээ байгуулсан. 2025 оны 1-3 дугаар улирлын байдлаар Харуул хамгаалалтын зардалд нийт 0.54 сая төгрөгийн өглөгтэй байсан ба тухайн харуул хамгаалалтын байгууллагатай хийсэн гэрээний мөнгөн дүн 0.33 сая төгрөг боловч 2025 төсөв 0.27 сая төгрөгөөр батлагдсанаар өр үүссэн. 2025 оны 11 сард санхүүжилт нэмж орж ирсэнээр харуул хамгаалалтын өглөгийг барагдуулсан. Мөн тээврийн хэрэгслийн татвар болон газрын төлбөрт нийт 0.17 сая төгрөгийн өр үүсэхээр байна. Багануур дулааны станц нь 2025 оны 2 болон 3 дугаар сарын тооцоог буруу хийж явуулсанаас үүдэн 3.3 сая төгрөг илүү төлөлттэй байна. Дээрх байгууллагуудтай Тус газрын 2025 оны II дугаар	
--	----------------------------	--	--	--	---	---	--

					улирлын санхүүгийн тайлангаар тайлант хугацааны өглөг, авлагыг баталгаажуулж хамтран ажилласан гэрээт байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэж санхүүгийн тайланд хавсаргасан. Сангийн нягтлан бодох бүртгэл: Төрийн сан болон банкуудтай дансны орлого, зарлага, үлдэгдэл мөн банк хоорондын шимтгэл, банкны хүүний орлого зэргийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажилласан. Тус газрын 2025 оны II, III дугаар улирлын санхүүгийн тайлангаар тайлант хугацааны өглөг, авлагыг тооцоо нийлсэн акт, дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулан ажилласан. Мөн эхний хагас жил болон 3-р улирлын тайлангаар тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгалын байцаагч, хамралт орлогын шимтгэлийн өр хариуцсан мэргэжилтэн, хяналтын байцаагч тус бүртэй сангийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн баталгаажуулсан. Тайлант хугацаанд 907 даатгуулагчийн 42.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс системийн хөгжүүлэлт бүрэн хийгдээгүй байгаагаас шалтгаалан 2024 онд хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй 397 даатгуулагчийн 13.8 сая	
--	--	--	--	--	---	--

						төгрөгийн алдангийн шимтгэл давхар бүртгэлтэй байна. Мөн 2025 онд хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй даатгуулагчдын алдангийн шимтгэл, 2025 он дуусталх шимтгэлээ төлсөн даатгуулагчдын нийт дүн байна. Тайлант оны эхний хагас жилээр болон III дугаар улирлын тайлангаар тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгалын байцаагч, хамралт орлогын шимтгэлийн өр хариуцсан мэргэжилтэн, хяналтын байцаагч тус бүртэй сангийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн баталгаажуулан ажиллана.	
Зорилт 2.1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.1	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаард-лагагүй	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөн ий биелэлтийн хувь	2024 онд 418 хүнийг сайн дурын даатгалд, үүнээс 56 малчин хамруулав.	Сайн дурын даатгалд шинээр 151 хүнийг үүнээс 22 малчин шинээр хамруулж төлөвлөгөөг биелүүлсэн байна.	НДЕГ-ын даргын 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/10 дугаар тушаалаар шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тоон төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөө ёсоор 2025 онд 151, оны тайлант хугацаанд 2025.11.30-ны байдлаар 138 даатгуулагчийг сайн дурын даатгалд шинээр хамруулахаас 322 даатгуулагчийг хамруулж, төлөвлөгөөг 233 хувиар биелүүлээд байна. Шинээр даатгуулсан даатгуулагчийг ангилала	

						ар нь авч үзвэл - Малчин 33, - 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 27, - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ 11 байна. - Сайн дурын энгийн 251 даатгуулагч байна.	
2.1.2	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаардлагагүй	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөн ий биелэлтийн хувь	2024 онд 30 ажил олгогч, 195 хүнийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог шинээр 18, даатгуулагчийн тоог шинээр 108 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	НДЕГ-ын даргын 2025.01.20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар шинээр хамруулах ажил олгогчийг 18, албан журмаар даатгуулагчийг 108 байхаар тоон төлөвлөгөөг баталсан. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар шинээр хамруулсан 14 аж ахуйн нэгж, 109 даатгуулагчийн хамруулсан байна.	
2.1.3	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 70-аас доошгүй хувиар бууруулах;	-	Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 2,994.0 сая төгрөгт хүрсэн.	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2,627.6 сая төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	2025 оны 11 сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн нийт авлага 6,379.9 сая төгрөг байна. Үүний 2.1.4-д зааснаас бусад байгууллагын авлага 3,179.89 сая төгрөг байна. Үүний дотор 2024 оны жилийн эцсийн 84 байгууллагын /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ 2,994.2 сая төгрөгийн авлагаас 75 байгууллагын 1,965.6 сая төгрөгийг барагдуулж оны эхний авлагыг	

						эхний 11 сарын байдлаар 65.6 % бууруулан ажилласан.	
2.1.4	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх;		Шимтгэлийн өргүй гарсан байх.	Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 1,729.5 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 44.0 сая төгрөг байна.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	2024 оны жилийн эцсээр Төсөвт нэг байгууллагын шимтгэлийн өр 1,729.5 сая төгрөгийн төлбөрөөс 572,2 сая төгрөгийг барагдуулсан. Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 44.0 сая төгрөг байгаагаас бүрэн барагдуулсан байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар төсөвт байгууллагын шимтгэлийн өр 3,194.98 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 5.03 сая төгрөг байна.	
2.1.5	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна.	Нийгмийн даатгалын санд 46,400.7 сая төгрөгийн орлого хуримтлуулав.	Нийгмийн даатгалын санд 42,902.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлнэ.	2025.11.30-ны байдлаар 38,154.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 33,050.9 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 86,85%-иар биелүүлсэн.	
Гүйцэтгэлийн дундаж хувь							
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын	-	- Мэдээлэл байршуулалтыг 100	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024	Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод,	Тайлант хугацаанд байгууллага нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2–8.6-д заасан 37	

	хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;		хувьд хүргэнэ.	оны жилийн эцсийн байдлаар 99,81 хувийн гүйцэтгэлтэй байна.	нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	төрлийн мэдээллийг хуулийн хугацаанд байгууллагын цахим хуудсанд байршуулж, Baganuur.ndaatgal.mn сайтад нийтэлсэн мэдээллийг shilen.gov.mn системтэй холбоос хаягаар холбон, ил тод байдлын хэрэгжилтийг ханган ажиллав. 1 дүгээр улиралд Shilen.gov.mn системд нийтэлсэн тайлангийн шалгалтаар: Чиг үүрэг, стратеги 70%, Хүний нөөц 83%, Төсөв, санхүү, худалдан авалт 83%, Үйлчилгээ 73%, Бусад мэдээлэл 41%, Нийт үнэлгээ: 74%. 2 дугаар улиралд Shilen.gov.mn системийн үнэлгээгээр: Чиг үүрэг, стратеги 91.03%, Хүний нөөц 97.62%, Төсөв, санхүү, худалдан авалт 88.33%, Үйлчилгээ 88.89%, Бусад мэдээлэл 91.67%, Нийт үнэлгээ 91.43%. 3 дугаар улиралд Shilen.gov.mn-д оруулсан мэдээллийг шинэчлэх шаардлагаар НДЕГ–ДАМГ-с буцаасан тул тайлангийн хугацаа хэтэрч, үнэлгээ хийгдээгүй. 4 дүгээр улиралд Хуулийн дагуу 37 төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, shilen.gov.mn системд холбон хуулийн хугацаанд нийтэлж ажиллана.	
3.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн	-	- Сар бүрийн хугацаанд байршуулсан	Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг	Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл	

	дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуулалтад хяналт тавих;		мэдээлэл 100 хувь байна. Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.	мэдээлэл байршуулалт 98.45 хувьтай байна.	хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 148 мэдээг https://info.shilendans.gov.mn/ цахим хуудаст байршуулж, мэдээлсэн. Тайлант хугацаанд хугацаа болоогүй 121 мэдээ хүлээгдэж байна. Шилэн дансны цахим системд бүх мэдээг цаг тухайд нь мэдээлж, “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т байршуулсан хэдий ч 2 төрлийн мэдээг хуулиар тогтоосон хугацааны дараа засварласанаар хугацаа хэтэрсэн төлөвт шилжсэн. Мөн олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т тухай бүр байршуулав. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025.02.25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар Албан даалгавраар өгөгдсөн үүрэг даалгавартай холбогдуулан шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2025 оны 01 дүгээр улирлын мэдээллийг НДЕГ-ын ДАМГ-аас 2025 оны 01-03 дугаар сарын шилэн дансыг шалгасан байна. НДЕГ-ын даргын 2025.06.27-ны өдрийн 02/1583 дугаартай “Ажил зохион байгуулах” тухай албан бичгийн дагуу тус газрын 2025
--	---	--	---	--	---	--

					оны 01-06 дугаар сарын Шилэн дансны цахим хуудасны хөтлөлт, мэдээлэл байршуулалт, холбогдох шийдвэр, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхийг хянан шалгахад мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 171 мэдээ, мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ цахим хуудаст байршуулахаас 94 мэдээ байршуулсан, 2 мэдээ нь засвар орсон тул хугацаа хоцорсон төлөвт шилжсэн, хугацаа болоогүй 77 мэдээ хүлээгдэж байв. Мөн олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т тухай бүр байршуулсан байна. Шалгалтын тайланг газрын дарга, санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэст танилцуулж шилэн дансанд байршуулсан 3 гүйлгээний мөнгөн дүнг сангийн нягтлан бодогчоор засуулсан, мөн 2025 оны 01-03 дугаар сарын гүйлгээг давхар шивж оруулсан тул холбогдох албан хаагч нарт танилцуулав. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх зорилгоор Багануур дүүргийн Дотоод аудитын албаны	
--	--	--	--	--	---	--

						аудитороос шилэн дансны тухай хууль, анхаарах асуудлын талаар зөвлөгөө авч, сургалт зохион байгууллаа.	
Зорилт 3.1: “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1.1	Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах,	-	- Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь, - Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь.	НДЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу 1 байгууллагад хяналт шалгалт хийсэн. Салбарын хяналтаар 5 зөрчил илрүүлж 7.4 сая төгрөгийн акт ногдуулж 5.4 сая төгрөг барагдуулж, барагдуулалтын хувь 72 хувьтай байна.	Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	Гадаад болон дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд дотоодын хяналт шалгалтаар 19 ажил олгогч, байгууллагын 49 даатгуулагчид холбогдох 23.4 сая төгрөгийн акт тогтоогдож 18 ажил олгогчийн 23.4 сая төгрөгийг актын төлбөрийг барагдуулж, 0.0145 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2025 оны эхний үлдэгдэлтэй 4 ажил олгогчийн 0.195 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг бүрэн барагдуулсан байна. Улсын байцаагчийн актын барагдуулалт 99,9%-тай байна. 965 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг материал, ажилгүйдлийн тэтгэмж авсан 369 иргэний тэтгэмжийн хувийн хэрэг материал, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмжийг 144 иргэнд, сувилалын зардал 319 даатгуулагчид, бааз хөрвүүлэх 28 хүсэлтийг сикос программ, нэгдсэн лавлагаатай тулган шалгалаа. Мөн жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн	

					чадвар түр алдсаны тэтгэмж нийт 2726 эмнэлгийн хуудасны бодолтыг шалган шийдвэрлэсэн байна. Оны эхний үлдэгдэлтэй 10 тэтгэвэр авагчийн 98,761.4 сая төгрөгийн актын төлбөр, өнгөрсөн оны хуурамч бичиг баримтаар тэтгэвэр тогтоолгосон 20 тэтгэвэр авагчид 409.8 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд буцаан төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн актын төлбөрийн оны эхний үлдэгдэл барагдуулаагүй байна. Тайлант хугацаанд 5 тэтгэвэр авагчид илүү болон дутуу олгосон 24.3 сая төгрөгийн акт тогтоогдож, 20.4 сая төгрөгийг барагдуулсан байна. 1 тэтгэвэр авагчид илүү олгосон 4.4 сая төгрөгийг 2025 оны 07 сараас төлж эхлэхээр төлөлтийн хуваарь байгуулан 0.5 сая төгрөгийг барагдуулж, 3.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Улсын байцаагчийн актын барагдуулалт 84%-тай байна. Оны эхний үлдэгдэлтэй ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон 3 даатгуулагчийн 6,89 сая төгрөгийг актын төлбөрөөс 1 даатгуулагчийн 1.1 сая төгрөгийг барагдуулж, 2 даатгуулагчийн 5,723 сая төгрөгийн үлдэгдэлтэй тухайн 2 даатгуулагчтай төлөлтийн хуваарь байгуулсан байна.	
--	--	--	--	--	--	--

						Тайлант хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон 9 даатгуулагчид 8,3 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоогдож, 3.5 сая төгрөгийг барагдуулан, 4,7 сая төгрөгийг барагдуулаагүй байна. Ажилгүйдлийн тэтгэмж дутуу олгосон 1 даатгуулагчид 2.2 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоогдож, 2.3 сая төгрөгийг бүрэн олгосон байна. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 2,0 сая төгрөгийг ҮОМШӨ даатгалын сангаас олгохыг тэтгэмжийн даатгалын сангаас олгож, НДЕХ-ийн 12 дугаар 12.2-т заасныг зөрчсөн тул тус зөрчилд акт тогтоогдож, залруулсан байна. Регистр нэгтгүүлэх 19 хүсэлтийг нотлох баримтад үндэслэн шийдвэрлэсэн байна. 2025.02.03-ны өдрийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу “Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг хэрэгжүүлэх заавар”-ын хэрэгжилтийг шалгахад 92 даатгуулагчийг хамруулж мэдээллийн баазад оруулсан, илэрсэн зөрчил дутагдалгүй байна. Цэргийн жилийг энгийн жилд шилжүүлж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох 6 даатгуулагчийн 11.0 сая	
--	--	--	--	--	--	---	--

					төгрөгийн нэхэмжлэхийг тулгахад тухайн цалинг мэдээллийн баазад оруулсан байх тул нэхэмжлэхээ шалгуулж, улсын төсвөөс тус шимтгэлийг төлүүлсний дараа тэтгэвэр тогтоохыг холбогдох байцаагч, хэлтсийн даргад зөвлөв. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025.11.10-ны өдрийн 07/2963 дугаартай “Шийдвэр хүргүүлэх тухай” албан бичиг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025.11.06-ны өдрийн А/306 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” тушаалын дагуу 2025.11.11-ний өдрөөс 2025.11.25-ны өдрийг дуусталх хугацаанд тус газарт ажил олгогчийн ирүүлсэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД-7), нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлан (НД-8)-д 2024-2025 онд нөхөн тайлагнасан, цалин хөлсний хэмжээг өөрчилсөн, устгасан, даатгуулагчийн регистр зэрэг үндсэн мэдээллийг засварласан, нэгтгэсэн байдлыг санхүүгийн болон холбогдох нотлох баримтад үндэслэн Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийгмийн ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын хэрэгжилтийг	
--	--	--	--	--	---	--

						шалгаж тайланг хүргүүлсэн байна.	
3.1.2	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025.02.14-ний өдөр баталсан “Аж ахуйн нэгж байгууллагад Нийгмийг даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн дагуу ерөнхий боловсролын Сод сургуулийн 2020-2024 оны санхүүгийн баримтад тулгуурлан, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд шалгаж байна.	
3.1.3	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын дагуу 21 байгууллагат шалгалт хийхээс 16 байгууллагын материалыг татан авч шалгаж байна. Тайланг 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.	
3.1.4	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны	Батлагдсан	-Шалгалт хийсэн объектын	-	Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт,	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн	

	орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	төсвийн хүрээнд	гүйцэтгэлийн хувь -Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах , -Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.		зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна.	баталсан 2025.01.07-ны өдрийн 13-07/06 дугаартай "Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу 2022-2024 онд олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч нар гүйцэтгэж, улсын байцаагчийн акт тогтоож шийдвэрлэсэн бөгөөд актын зарим хэсэгтэй тус газрын зүгээс санал нийлэхгүй тул шийдвэрийг эцэслээгүй байна.	
3.1.5	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 1 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах , - Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт	2024 онд 4 объектод хяналт шалгалт хийж, 2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1 албан шаардлага хүргүүлж ажилласан.	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 100 хувь шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Тус газарт Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч байхгүй тул Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нар шалгана.	

			хүргүүлсэн байна.				
3.1.6	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх,	-	-Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь, -НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо,	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т тухай бүр хүргүүлж ажилласан.	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	2024 онд Салбарын хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 07/08 дугаартай "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу шалгалтаар 2021-2023 онд тус дүүргийн Нийгмийн даатгалын газарт нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэлтэй Нүүрэнтэйн эсгий ХХК нь Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд шимтгэлийг дутуу тооцсон тул тус компанид Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 32/34 дугаартай Улсын ахлах байцаагчийн 2.1 сая төгрөгийн акт тогтоогдож, 2025.06.01-ний өдрийн байдлаар барагдуулаагүй байна. Тус компанийн захирал болон нягтлан бодогч нартай удаа дараа холбогдоход улсын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тайлбар өгсөн байна. Оны эхний үлдэгдэлтэй 1 тэтгэвэр авагчийн 1.2 сая төгрөгийн актын төлбөрөөс барагдуулаагүй байна.	
3.1.7	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн	-	Дотоодын хяналт, шалгалтын тайланг	Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн	Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар	Дотоод хяналт, шалгалтын тайланг үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган	

	даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;		хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах,	жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналтад тавьж ажилласан.	хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	баталгаажуулалт хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газар хүргүүлсэн. Тайлант онд дотоодын хяналт шалгалтаар тогтоогдсон актын 50.231 мян төгрөгийн акт тогтоож 41.625 мян төгрөгийг барагдуулж нийт барагдуулалт 82.6 хувь байна.	
Гүйцэтгэлийн дундаж хувь							
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1	Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх;		- 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. -Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн	2024 онд нийт 637 албан бичиг ирсэн. Тайлан мэдээг хугацаанд нь ирүүлсэн байдал 99.8 хувьтай байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Тайланд онд дээд газраас ирүүлсэн 45 эрх зүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн тогтоол шийдвэрийн биелэлт урьдчилсан байдлаар 93.3%-ийн үнэлгээтэй байна.	
4.2	Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг		-Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин газрын хэмжээнд 2024 онд	Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв	Даатгуулагчдаас ирүүлсэн хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгэж, бүртгэл хяналтын карт хөтлөн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, явц, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.	

	зохион байгуулах, үр дүнг тайлагнах;		-Өргөдөл шийдвэрлэл тийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	98.8 %-тай хэрэгжсэн байна.	гаргаж, хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд нийт 1733 хүсэлт бүртгэгдсэнээс 92,4%-ийг шийдвэрлэж ажиллав. Тэтгэвэр тогтоолгох цалингийн 2025 оны итгэлцүүр өөрчлөн батлагдсантай холбоотой Sicos программд өөрчлөлт хийх ажил хүлээгдсэнээс шалтгаалан 2025 оны 01 дүгээр сарын шинэ тэтгэврийн тогтоолт, олгох ажлууд удааширч 53 өргөдөл, 2024 оны жилийн эцсийн тайлан гаргахтай холбоотой сайн дурын даатгалын 4 өргөдөл хугацаа хэтэрч шийдэгдсэн бол тэтгэмжийн байцаагч албан ажлын шаардлагаар 2025.02, 03 дугаар сард үйл ажиллагааны нягтлан бодогчин албан үүргийг хавсарч ажилласан хугацаанд Төрийн өмчийн программд үндсэн хөрөнгийн мэдээлэл шивж, тайлан гаргах, НДЕГ-аас шалгалт ирсэн үеийн ажлын ачаалал огцом өссөнөөс тэтгэмжийн 49 өргөдөл тус тус хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Нийгмийн даатгалын цогц системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлаас шалтгаалан зарим даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох ажлууд удааширнаас үүдэн 11-11 төвд 7 гомдол бүртгэгдсэнийг тухай	
--	---	--	---	-----------------------------	---------------------------	--	--

						бүр судлан шийдвэрлэж, иргэдэд хариу хүргүүлж ажилласан. Албан журам, сайн дурын даатгалын шимтгэл давхардсан, илүү төлсөн шимтгэл буцаахаар ирсэн 46 өргөдлөөс 41-ийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, 4-ийг 2024 оны жилийн эцсийн тайлан гаргахтай холбоотой хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж хяналтын картыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. 1 даатгуулагчийн өргөдлийг хуулийн хугацаанд судалж байна Аж ахуйн нэгж, албан байгууллагаас нийт 78 албан хүсэлт ирүүлснээс шинээр бүртгүүлэх 14, байгууллагын удирдлага болон санхүүгийн ажилтны мэдээлэл шинэчлэх 40, тухайн болон өмнөх саруудын тайланд ажилтны мэдээллүүд алдаатай, ажил мэргэжлийн болон төрлийн код буруу, тайлан засуулах зэрэг 16, байгууллагын нэр, хэлбэр өөрчлөгдсөн, байгууллага шилжих болсон, Х тайлан өгөх зэрэг 8 хүсэлтийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн байна.	
4.3	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль		Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн	Хүний нөөцийн хөдөлгөөний мэдээллийн хувьд 2025.11.30-ны өдрийн байдлаар өөрийн саналаар чөлөөлөгдсөн 3, цомхотголоор 1, өөр	

	тогтоомжийн дагуу нөхөх;		журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна.	ажиллах нөхцөл боломжоор ханган ажилласан.	дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан байна.	байгууллага руу шилжсэн 1, өөр байгууллагаас шилжиж ирсэн 1, удирдах ажилтны сул орон тоо 1, гүйцэтгэх ажилтны сул орон тоо 1-тэйгээр үйл ажиллагаа явуулж байна. НДЕГ-ын даргын 2025.09.10-ны өдрийн А/238 дугаар “Дүүргийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтаар Багануур дүүргийн нийгмийн даатгалын газрыг 3 хэлтэс, 18 албан хаагчтай байхаар баталсан. Дээрх тушаалтай холбоотойгоор НДЕГ-ын даргын 2025.09.16-ны өдрийн 03/2241 “Тушаал, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу нийт 6 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулж, төрийн байгууллагын үйлчилгээний ажилтан албан тушаал дээр нэг албан хаагчийг цомхотгож, ЭБАТ болон нууцын ажилтныг томилж, харьяалах зөвлөлүүдийг шинэчлэн баталлаа. Хүний нөөцийн сарын мэдээг тухай бүр гарган хүргүүлсэн.	
4.4	Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн		Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна.	Цаг хугацаанд нь үнэн зөв гаргах.	Судалгааг үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Мэргэшлийн зэргийн нэмэгдэлд 12 албан хаагчийг, төрийн албаны зэрэг дэв нэмэгдүүлэхэд 1 албан хаагчийг, төрийн шагналд 2 албан хаагчийг, НДЕГ-н шагналд 3 албан хаагчийг,	

	нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх;					Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгуулахад 3 албан хаагчийг, тус газарт харьяалах ахмадын судалгаа зэрэг нийт 33 судалгааг цаг тухай бүр үнэн зөв, бүрэн гүйцэт гарган хүргүүлсэн.	
4.5	Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;		Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.	2023 оны А/11 дугаар тушаалын дагуу ажилчдын нийгмийн баталгааг хангах 3 жилийн төлөвлөгөө баталсан. Тус тушаалын хүрээнд төлөвлөсөн ажлыг 100 хувь хангаж ажилласан.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны дэд төлөвлөгөөг баталж, газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна.	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт”-ийн тайланг Захиргаа удирдлагын газарт 2025.12.02-ны өдрийн дотор гаргаж, хүргүүлсэн.	
4.6	Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;		Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна.	Тус газрын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хүргүүлсэн.	Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Тус газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд ёс зүй, харилцаа хандлага, сахилга хариуцлагатай холбоотой зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно. Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 3 зорилт 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 91.1%-иар ханган ажиллав. Өмнөх жил буюу 2024 оны ХАСХОМ-ийг 7 албан хаагч 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан мэдүүлж,	

					тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэв. Тайлант оны байдлаар шинээр ажилд томилогдсон 2, шилжиж явсан 1, шилжиж ирсэн 1, чөлөөлөгдсөн 2, нийт 7 албан хаагчийн өөрчлөлт хөдөлгөөн гарсан. Шинээр томилогдсон 2 албан хаагч ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэхгүй, шилжүүлэн томилогдсон албан хаагч нь ТЗ-7 зэрэглэлээс ТЗ-8 зэрэглэлд буурч шилжсэн тул ХАСУМ, ХАСХОМ мэдүүлээгүй болно. Нэг албан хаагч их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүллээ. НДЕГ-ын даргын 2025.09.10-ны өдрийн А/238 дугаар “Дүүргийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтаар Багануур дүүргийн нийгмийн даатгалын газрыг 3 хэлтэс, 18 албан хаагчтай байхаар баталсан. Дээрх тушаалтай холбоотойгоор НДЕГ-ын даргын 2025.09.16-ны өдрийн 03/2241 “Тушаал, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу нийт 6 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулж, төрийн байгууллагын үйлчилгээний ажилтан албан тушаал дээр нэг албан хаагчийг цомхотгосон. Хүний нөөцийн хөдөлгөөнтэй	
--	--	--	--	--	--	--

						холбоотойгоор 3 албан хаагчийн ХАСУМ-ыг журамд заасны дагуу АТГ-т илгээж хариуг авсанаар албан тушаалд томилогдсон. Тайлант онд ЭБАТ 2 удаа солигдож тухай бүр ажлыг хүлээлцүүлэв. АТГ-аас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч түгээлээ. Мөн тус газраас нийтэлсэн 13 удаагийн постыг олон нийтийн цахим сүлжээнд нийтлэв.	
4.7	2024 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх;		- Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна.	-	Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын байгууллага 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарлаж, тус аяны хүрээнд нийт 6 ажил олгогчийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж 2025.11.30-ны байдлаар 1,245.9 сая төгрөгийг төлүүлэхээс 502.5 сая төгрөг төлүүлж, 583.4 сая төгрөгийг шүүхийн шийдвэрээр албадан гүйцэтгүүлэх хүсэлт өгөөд байна. Багануур дүүргийн ШШГХ-ийн хамт олонтой 2025 оны 05 дугаар сард уулзалт хийж, НДЕГ-аас ШШГБ-тай байгуулсан “Санамж бичиг”-ийн хүрээнд МИМС ХХК-ийн судалгааг Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газарт 2025.11.30-ны	

						өдрөөр тасалбар болгон хүргүүлсэн.	
4.8	Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах;		-Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 83.6%-тай байв.	Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Тайланд онд дээд газраас ирүүлсэн 45 эрх зүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн тогтоол шийдвэрийн биелэлт урьдчилсан байдлаар 93.3%-ийн үнэлгээтэй байна.	
Зорилт 4.1: “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1.1	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах;		-Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах, -Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна.	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	АТГ-аас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад ЭБАТ-ууд оролцож, мэдээлэл авч түгээлээ. Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнээс дээш их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор мэдээлэх гэсний дагуу нийт албан хаагчдад, түүний дундаас ХАСХОМ гаргагч нарт онцлон сануулж, хууль хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв. Мөн газраас зохион байгуулсан сургалтад магадлагч эмч, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд нийт 10 хүн оролцсон ба уг сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Тус газрын авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд	

						байгууллагын цахим хуудсуудаар дамжуулан Авлигатай тэмцэх газар (АТГ) болон Нийгмийн даатгалын газар (НДГ)-ын цахим хуудсаас нийт 32 мэдээллийг хуваалцаж, бүх алба хаагч, ажилтныг уг мэдээллийг түгээж, олон нийттэй хуваалцахыг уриалав. Мэдээллийн самбар дээр Авлигатай тэмцэх газрын “Гомдол, мэдээлэл хүлээн авах (11) 31-11-31” дугаар бүхий зурагт хуудас болон ЭБАТ-ын гомдол, мэдээлэл хүлээн авах талаарх зурагт хуудсыг тус тус байршуулж ажиллалаа.	
4.1.2	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;		- Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -Албан хаагчдыг 100% хамруулсан байна.	Албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх 50 удаагийн сургалтад давхардсан тоогоор 284 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна.	Газрын даргын баталсан сургалтын төлөвлөгөө, ХНХЯ, НДЕГ -аас ирүүлсэн чиглэлийн дагуу тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөл, НДЕГ, Багануур дүүргийн ЗДТГ, бусад байгууллагаас цахим болон танхимаар зохион байгуулсан 99 удаагийн сургалтад давхардсан тоогоор 413 ажилтан, албан хаагчид оролцож, мэргэжлийн болон холбогдох бусад сэдвүүдээр мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.	
4.1.3	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд		- Даатгуулагч ид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас	Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 13 удаагийн сургалтад 311 аж ахуйн нэгж, 5 удаагийн явуулын	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг	Нийгмийн даатгалын тухай шинэчилсэн хууль тогтоомж, шинэчлэгдсэн программ хангамж болон цахим үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөгөө хүргэх	

	чиглэсэн сургалт зохион байгуулах;		доошгүй хувиар зохион байгуулах, - 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, -Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна.	үйлчилгээнд 1264 иргэд, даатгуулагчийг хамруулав.	дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна.	зорилгоор ЗХХ-ийн дарга Г.Батболд “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга”, “Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлууд” сэдвийн хүрээнд нийт 16 удаагийн танхимын сургалтыг, ахлах нягтлан бодогч Ц.Солонго арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу 5 удаагийн сургалтад мэдээлэл түгээв. Тайлант хугацаанд нийт 13 удаагийн сургалт, малчдын өдөрлөг 1, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, ажил олгогчид зориулсан сургалт, зөвлөгөөнийг цувралаар зохион байгууллаа.	
Зорилт 4.2: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.2.1	Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах;	-	Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна.	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна.	2024 оны I улиралд тус газрын ажлын байрыг 88 үзүүлэлтээр хяналт хийж хяналтын дүгнэлтийг хүргүүлсэн. 2025 онд тус хяналтын дүгнэлтийг үндэслэн дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. -Үйлчилгээг хүртээмжтэй явуулах үүднээс хяналтын байцаагч нарын өрөөг сольж иргэдэд аль болох чирэгдэлгүй ойлгомжтой байдлаар өрөө тасалгааны зохион байгуулалтыг хийж гүйцэтгэсэн.	

						-Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандартыг хангуулах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламжийн хонхыг засварлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэргэнцрийн замын наалтыг шинэчлэхээр төлөвлөж байна. -Үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд Багануур дүүргийн Насан туршийн боловсролын төвөөс “Харилцаа, хандлага” сэдэвт сургалтыг нийт 20 албан хаагчид зохион байгуулсан. -Call pro үйлчилгээний хяналтыг сайжруулж дуудлага хүлээн авах, утсаар харилцах, үйлчилгээг 100% хүргэх тал дээр анхаарч 2025 оны нийт дуудлагын 93.25%-г хүлээн авч иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	
4.2.2	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;	-	Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна	Ирсэн дуудлага 4942, дуудлага алдалт дунджаар 29 %.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна.	Тус газар нь тайлант хугацаанд нийт 5,874 дуудлагаас 5477 дуудлага хүлээн авч, нийт дуудлагын 93,25%-ийг хариулсан байна.	
4.2.3	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр	-	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг - “Рийл” улиралд 3-аас	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий	Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь олон нийтэд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэж, сурталчлах зорилгоор Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар	

сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах;		доошгүй удаа; - “Постер” сард 3-аас доошгүй удаа; - “Видео контент” улиралд 1 удаа; Хэвлэл мэдээллийн байгууллага ар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа;	сурталчилж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан. Үүнд: • Постер - 15 • Видео контент -2 • Хэвлэл мэдээллийн байгууллага ар дамжуулсан мэдээ -2 Фэйсбүүк-д байршуулсан мэдээний тоо - 171	газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.	Фэйсбүүк хуудасны нийт контентын үзүүлэлт Нийт байршуулсан контент: 637 нийтлэл (голчлон Гэр бүл, нийгмийн хамгааллын бодлого болон НДЕГ-ын мэдээлэл) Хүрсэн үр дүн: 89,722 хандалт 541 хариу үйлдэл (reaction) 87 сэтгэгдэл 677 хуваалцалт Бэлтгэн хүргэсэн бусад контент: 27 постер 2 ширхэг reels / видео контент “Багануурын мэдээ” веб сайтаар нийтэлсэн 7 мэдээлэл Дагагчдын өсөлт: 2025.01.01 4050 дагагч 2025.11.30 4162 дагагч 2.86%-иар өссөн. Үүнээс гадна Нийгмийн даатгалын ерөнхий газрын Facebook хуудас болон Instagram хаягийн хандалтыг нэмэгдүүлэх зорилгоор тус газрын нийт албан хаагчид тухайн хуудсуудыг дагаж, идэвхтэй ашиглаж байна.
---	--	---	--	---	---

Зорилт 4.3: “Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.3.1	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх		Ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, удирдамж, тайлан	2024 онд 1 удаа зохион байгуулсан байна. 2024 онд 1-4 удаа зохион байгуулсан.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Ижил мэргэжилтний үзлэгийг 2-р улиралд Багануур, Налайх, Дорноговь, Булган аймагтай, 3-р улиралд Баянзүрх, Говьсүмбэр аймгуудтай хамтран зохион байгуулсан. Үзлэгийн үр дүнд туршлага солилцон, дотоодын хяналтыг сайжруулах мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн ажиллав.	
			Дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан		Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулган шалгах ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж,	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн хяналтаар нийгмийн даатгалын сангаас 483, нийгмийн халамжийн сангаас 320, даатгуулагч хүний мэдээллийг тулгахад нас барсан 3, сан хооронд шилжсэн 2, өвчний ангилал нь заалттай зөрсөн 1, өвчний шалтгаан нь оноштой зөрсөн 2 иргэний мэдээллийг засаж бүртгэлээ.	

					зөрчлийг арилгаж ажилласан байна.		
4.3.2	Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх		Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	-	Аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд хийсэн судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна.	НДЕГ-н даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 01/1244 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, түүнд зонхилох өвчин, шалтгаан зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор дүүргийн ИТХ-н төлөөлөгч, дүүргийн Засаг дарга холбогдох удирдлагууд, ӨЭМТ-н дарга нарт нээлттэй мэдээллийг 37 албан хаагчдыг хамруулан хийв. Дүүргийн хүн амын ХЧА-н үндэслэлд хяналт хийх, ХЧА-г бууруулах арга замыг судлах, цаашид арга хэмжээний санал боловсруулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2025.06.04-ний өдрийн А/152 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэний заалтын үндэслэл, эмчийн явцын хяналт, эмнэлгийн анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт, эмх цэгцэд хяналт, үнэлгээ хийж хороодоор ажиллан 300 гаруй иргэдийг дахин магадлав. Зөвлөлийн хурлаар хугацаагүй шийдвэртэй 93 иргэнийг дахин магадлахад 19 иргэний хугацаа өөрчлөгдсөн, 4 иргэний /хавдарын заалттай/	

						хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалсан байна.	
4.3.3	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах		Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан	2024 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан	Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	Тус дүүргийн Эрүүл мэндийн төв нь medsoft програм ашиглаж цахимд шилжин цаасгүй эмнэлэг болсон. Иргэний эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээний дүгнэлт нь цахимд бичигдэж иргэн өөрөө цахим хуудаснаас хэвлэх, эмнэлгийн цахим бүртгэлээс хэвлүүлэн авч амбулаторийн картанд хавсарган наадаг бөгөөд энэ нь эмх, цэгцтэй, хаяж үрэгдүүлэхэд дахин хэвлээд авах боломжтой. Төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн үечилсэн дүгнэлтийн бичилт, өвчтөнг хянах хяналтын карт, өвчтөн хөтлөх уналт таталтын карт, оношийн баталгаажилтанд 4-өөс дээш удаа дотоодын хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилган арга хэмжээ авч ажилласан. ЭММЗ-ийн хурлаар орж буй иргэдийн амбулатори, хяналтын картыг сайжруулах аян зохион байгуулж, үүний үр дүнд эмэгтэйчүүд, чих хамар хоолой, нүд, сэтгэц, дотрын амбулаторийн карт, өрхийн эмнэлгүүдийн хяналтын картны эмх цэгц сайжирсан байна.	

			Сургалт, өдөрлөг, цахим сурталчилга аны тоо, мэдээлэл авсан иргэдийн тоо, тайлан	2024 онд 3-аас доошгүй удаагийн сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгсөн	Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн магадлалын талаар ерөнхий мэдээлэл өгч, иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгаа хийж мэдээллээр хангасан байна.	Дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын байдал, түүнд зонхилох өвчин, шалтгаан зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор дүүргийн ИТХ-н төлөөлөгчид, дүүргийн Засаг дарга, холбогдох удирдлагууд, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт нээлттэй мэдээлэл хийж 37 албан хаагчдыг хамруулав. Дүүргийн ИТХ, ЗДТГ-ын мэдээний цахим хуудас болон байгууллагын цахим хуудсаар дүүргийн эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй өвчлөл түүний тархалт, хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн өвчний ангилал, хороо тус бүрээр хүн амд эзлэх хувь сэдвээр 2 удаа яриа өгч ажиллалаа. Байгууллагын цахим хуудсанд 2 удаагийн постер мэдээлэл байршуулсан. ЭММЗ-н хуралд биеэр ирж оролцсон иргэн, хороодод ажиллахад хамрагдсан иргэд зэрэг 364 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан..	
4.3.4	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн		Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо	2024 онд 5 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг Төв	Дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна.	Эрүүл мэндийн магадлал болон бусад албан үүрэгтэй холбоотой 41 албан бичиг ирж, хариутай 3 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн. НДЕГ-аас ирсэн ЭММЗ-ийн программыг сикос системд холбох үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, 11 дүгээр сарын 12-	

	хэрэгжилтийг зохион байгуулах			зөвлөлд хүргүүлэн ажилласан.		ны өдрөөс шинэ системээр даатгуулагч хүний хөдөл-мөрийн чадвар алдалтыг шийдвэрлэж эхэллээ. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон, сунгасан, цуцалсан шийдвэр бүрэн цахимжиж, цаасан акт ашиглахгүй болж, тэтгэврийн дэд системд мэдээлэл шууд татагдаж, тэтгэврийн өөрчлөн тогтоолтыг хийх, даатгуулагч иргэн шинээр хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр тогтоолгох хүсэлт цахимаар илгээх боломжтой боллоо.	
Зорилт 4.4: “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.4.1	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх		Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.	Sicos системд шинээр нийт 17 ажил олгогч байгууллагын мэдээллийг бүртгэхэд үндсэн мэдээлэл, ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр зэрэг нь улсын бүртгэлийн мэдээллийн сангаас автомаар татагдсныг тулган шалгаж, цахим системд хэрхэн нэвтрэх заавар зөвлөгөөг өгөв. 2025.12.05-ны өдрийн байдлаар аж ахуйн нэгж, албан байгууллагаас нийт 78 албан хүсэлт ирүүлснээс шинээр бүртгүүлэх 13, байгууллагын удирдлага болон санхүүгийн ажилтны мэдээлэл шинэчлэх 40, тухайн болон өмнөх саруудын тайланд ажилтны мэдээллүүд алдаатай, ажил мэргэжлийн	

						болон төрлийн код буруу, тайлан засуулах зэрэг 16, байгууллагын нэр, хэлбэр өөрчлөгдсөн, байгууллага шилжих болсон, Х тайлан өгөх зэрэг 9 хүсэлтийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн байна. Sicos системд шинээр нийт 17 ажил олгогч байгууллагын мэдээллийг бүртгэхэд үндсэн мэдээлэл, ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр зэрэг нь улсын бүртгэлийн мэдээллийн сангаас автомаар татагдсныг тулган шалгаж, цахим системд хэрхэн нэвтрэх заавар зөвлөгөөг өгөв.	
			Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх			Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна.	
4.4.2	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх;		Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байхад дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	- Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байхад - Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	Албан журмын болон сайн дурын даатгал давхардсан 32 даатгуулагчийн мэдээллийг системд залруулан бүртгэж ажилласан.	

			Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	давхардуулан бүртгэхгүй байхад - Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байхад анхаарч ажиллалаа.	Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	Сайн дурын даатгуулагчдын сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуулгыг даатгуулагч бүрээр системээс шүүн давхардуулан бүртгэхгүй анхааран ажиллаж байна.	
			Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх		Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна.	Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байхад анхаарч ажиллалаа.	
4.4.3	Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах;		Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах	Нийгмийн даатгалын программ хангамж шинэчлэгдсэнтэй холбоотой байцаагч, албан хаагчдын хандах эрхийн тохиргоог https://.sicos.ndaatgal.mn/ дээр олгон ажиллаж байна. Журмын хүрээнд компьютерийн аюулгүй ажиллагааг ханган албан хаагчдад и-мэйл хаяг ашиглах талаар мэдээлэл зөвлөмж хүргэж, ажлаас чөлөөлөгдсөн 3	Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвийн захирлын 2023 оны А/33 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагуудын хэрэглэгчийн болон сервер компьютерийн ашиглалт, тэдгээрт хандах хэрэглэгчийн эрх, нууцлал хамгаалалт, аюулгүй байдлын журам”-ын хүрээнд дараах өөрчлөлтүүдийг хийв. Үүнд: sicos.ndaatgal.mn цахим системд хандах эрхтэй байсан Шилжиж явсан 1 албан хаагч, Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 3 албан хаагчийн хандах эрхийг бүрэн цуцлав. Шинээр томилогдсон 2 албан хаагч, шилжиж ирсэн 1 албан	

				албан хаагчийн хандах эрхүүдийг цуцлах, ажилд томилогдсон 3 албан хаагчид холбогдох эрх нээлгэх хүсэлтийг НДЕГ-ын дэргэдэх МТТ-д хүргүүлж, шийдвэрлүүлсэн.		хаагчид системд хандах шинэ эрх олгож, тохируулан бүртгэв.	
			МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх			Байгууллага дотор албан тушаал өөрчлөгдөн шилжсэн 6 албан хаагчийн хандах эрхийг шинэ албан тушаал, чиг үүргийн дагуу шинэчлэн тохируулж ажилласан.	
						Системд давхардсан тоогоор 6279 даатгуулагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэх, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, гэрээний төрөл шинэчлэн бүртгэн ажиллаж байна.	
					МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвийн захирлын 2023 оны А/33 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагуудын хэрэглэгчийн болон сервер компьютерийн ашиглалт, тэдгээрт хандах хэрэглэгчийн эрх, нууцлал хамгаалалт, аюулгүй байдлын журам”-ыг нийт албан хаагчдад танилцах хуудсаар дамжуулан танилцууллаа. Тус журмын хүрээнд байгууллагын компьютерийн аюулгүй ажиллагааг хангах, и-мэйл хаяг ашиглахтай холбоотой мэдээлэл, зөвлөмжийг албан хаагчдад хүргэх, мөн ажлаас чөлөөлөгдсөн 4 албан хаагчийн хандалтын эрхийг цуцлах, шинээр томилогдсон 3 албан	

						хаагчид холбогдох эрхийг нээлгэх хүсэлтийг НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвд хүргүүлж, шийдвэрлүүлсэн болно. Мөн НДЕГ-аас 5 ширхэг HP компьютер, 5 ширхэг гурван үйлдэлт сапоп принтер ирсэнийг байцаагч, алба хаагчдад суурилуулж, Нийгмийн даатгалын программ хангамжийг тохируулав.	
Гүйцэтгэлийн дундаж хувь							
Гүйцэтгэлийн нийт дундаж хувь							

ТАЙЛАН ХЯНАСАН:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАГНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

Р.ӨНӨРЖАРГАЛ

..... оны дугаар сарын

..... оны дугаар сарын





7021-0021



baganuur.ndaatgal.mn



Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар